MMINFO.
18 дахь жилдээ
# МОНГОЛЫН МЭДЭЭ
Хүн ам 3,118.684... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр
2016.12.01. Пүрэв. №217, 218 (4587, 4587) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг



ЧУХАЛ ХҮН

Ж.БАТЖАРГАЛ: АЙМГИЙНХАА ХЭРЭГЛЭЭГ ӨӨРСДИЙН ЧАНАРТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР ХАНГАХ БОДЛОГО БАРЬЖ АЖИЛЛАНА

**VI-VII нүүрт**

**ОНЦЛОХ ХУУДАС**

САЛБАРТАА ГОЛОГДОХГҮЙ САЙД

**V нүүрт**

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




Дугаарын 60 мөр

## Ядуурлыг бууруулах төсөл буюу сүлжээний луйвар

Н.ПУНЦАГБОЛД

Зуд болохоор нохой зоолдог гэдэг үг байдаг даа. Түүнтэй адил улс орон жаахан хямраад, иргэдийн гар дээр бэлэн мөнгө бага сага хомсдоод эхлэхээр л янз бүрийн сүлжээний бизнес цэцэглэж эхлэх юм. Сүүлийн үед цахим ертөнцийг ашиглаж бизнес хийж байгаа сүлжээчид борооны дараах мөөг шиг л олширч байна. Хонгконгийн 520 ам.долларын төсөл, Казахстаны ядуурлыг бууруулах GTime, "Алтан өндөг" "Баяндалай" энэ тэр гээд л сүлжээний бизнесүүд үргэлжилнэ. Тэр дундаа Казахстаны ядуурлыг бууруулах GTime төсөл нэлээд газар авч эхэллээ.

**Төгсгөл нь III нүүрт**

ДУУЛИАНЫ МӨРӨӨР

# Н.АЛТАНХУЯГ: Ц.ЭЛБЭГДОРЖИЙН ҮГЭНД ОРОХГҮЙ БОЛ ШОРОНД ОРДОГ АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨ БИ ЯВААГҮЙ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Ж.ОТГОН

АТГ-аас өчигдөр Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийг сэжигтнээр тооцож зарлан дуудах хуудас хүргүүллээ. Хэрэв ирэхгүй бол албадан ирүүлнэ гэдгээ ч мэдэгдсэн юм. Тэгвэл Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг АТГ-т мэдүүлгээ өгөхөөр очихдоо өмгөөлөгчийн хамт ирсэн. Түүний өмгөөлөгчөөр өмнө нь Л.Гансүхийн өмгөөлж байсан Ц.Баасандорж байгаа аж. АТГ-т орохоосоо өмнө Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг сэтгүүлчдэд мэдээлэл өгсөн юм. Тэрбээр "Өнөөдөр /өчигдөр/ 14:00 цагийн орчим надад зарлан дуудах бичиг ирсэн. Тэгээд би одоо ирж байна.

Юу болчив гэхээр Ерөнхийлөгчид нэр дэвшинэ гээд хэлчихсэн чинь нилээн их үйл явдал өрнөх шинжтэй. Эртээд нэвтрүүлэгт орж, Монголын нийгэмд болохгүй байгааг, тэр дундаа цөөхөн хэдхэн хүн Монголын хамаг баялагийг буюу "Оюутолгой", "Тавантолгой", "Эрдэнэт", "Саусгоби Сэндс" гээд сорчлоод завшаад байгааг хэлчихсэн. Тэгсэн манай Ц.Элбэгдорж болоод тэдний бүлэглэл амь тавьж байгаа бололтой юм. Цөөхөн хоногийн дотор 3-4 эмэгтэй хүнийг шоронд хийллээ. Өнөөдөр харин намайг ир гэлээ. Тэгээд би ирж байгаа юм. Ер нь манай Ерөнхийлөгч болон түүний бий болгочихсон хууль, хяналтын байгууллага дотор нэг хонгил байдаг гэж би өнгөрсөн дөрөвдүгээр сард хэлж байсан. Намайг тэр хонгил руугаа шахаж оруулах гэж их олон жил оролдож байгаа. Ерөний сайд байх үеэс л элдэв зохиомол хэрэг үүсгэж байсан. Сая миний ойрын хүмүүсийг барьж хийгээд тэд нартайгаа холбогдуулж, тэр зохиомол хэрэгт оруулж байгаа байх. Үүнээс нэг их айж, ичээд байх юм байхгүй ээ. Ер нь үнэн хэзээд ялна гэж бодож байгаа. Би хоёр зүйлд л харамсч байгаа. Намайг эртхэн дуудаж авчраад асуучихгүй. Л.Гансүх, Б.Мөнгөнтуяагаас эхлээд олон хүнийг шоронд тарчилгаж, хамгийн сүүлд төрсөн дүү хамаатнуудыг хүртэл шорон гяндангаар тарчлаадаг явдлыг болих хэрэгтэй. Намайг тэр шорондоо хийчихээд, тэр хүмүүсийг гаргах цаг нь одоо болсон байх гэж бодоод ирж байгаа юм. Хоёр цагийн өмнө мэдэгдээд, жоохон давчуу л ирлээ. Аягүй бол Н.Алтанхуяг ирсэнгүй гэх зэргээр шалтаглах арга зам хайсан байх. Төгсгөлд нь би нэг юм хэлчихье. Ер нь Ц.Элбэгдорж бид нар 1990 оноос ардчиллын төлөө явсан. Ц.Элбэгдоржийн үгэнд заавал орох ёстой. Хэрэв Ц.Элбэгдоржийн үгэнд орохгүй бол шоронд ордог ийм ардчилалын төлөө би яваагүй. Ийм хоёрхон сонголттой ардчилал Монголд байж болохгүй, ард түмэн минь. Ер нь бол би Ц.Элбэгдоржийн үгэнд ормооргүй байна. Харин улс орныхоо төлөө зүтгэмээр байна. Шоронд хийсэн ч гэсэн бууж өгөхгүй тэмцэлдэнэ" гэлээ. Яг энэ асуудлаар АН-ын Гүйцэтгэх зөвлөл өчигдөр үдээс хойш "Шонхор тауэр"-т хуралдсан юм. Хурлаар сүүлийн үед АН-ынхныг хууль хяналтынхан барьж хорьж, шалгаж, мөрдөж байгаа асуудлаар дуугарах ёстой гэсэн байр сууриа намынхан илэрхийлсэн гэнэ.

Дугаар шилжих мөчид АН-ын Гүйцэтгэх зөвлөлийн хурал үргэлжилж байлаа.

ДУУЛИАНЫ МӨРӨӨР

# Монголын эдийн засагт МӨДДӨӨ НАР ТУСАХГҮЙ НЬ

Б.ӨНӨРТОГТОХ

Ийм дүгнэлтийг би гаргасангүй. Эдийн засаг, уул уурхайн чиглэлээр тууштай судалгаа хийж, уул уурхай, банк санхүүгийн салбарт өрнөж буй уналт, өсөлтийг анхааралтай ажиглаж байгаа судлаачид, эдийн засагчид үүнийг хэлж байгаа юм. Ёрлоод хэлэхэд, ирэх онд ам.долларын ханш суларна гэсэн хүлээлт байхгүй байгааг нуух юун. Монгол Улсын хувь заяа үндсэндээ бүрхэг байдалд орчихлоо. Төв банк бодлогын хүүгээ 15 хувьд хүргэж, ОУВС-ын "Стэнд бай" хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтээ хүргүүлсэн ч, энэ хоёр шийдвэр эдийн засгийг хөл дээр нь босгож, сэхээнээс гаргана гэсэн найдвар биш юм. Бодлогын хүү нэмэгдлээ гээд аж ахуйн нэгжүүд дампуурлаас гарах бус харин ч өндийж байсан тэднийг бүр мөсөн хэвтүүлэх шийдвэр болсныг МҮХАҮТ-аас саяхан мэдэгдсэн билээ. Эдийн засгийн дампуурлыг хаа хаанаа хүлээн зөвшөөрч, ирэх оны төсөвт баахан халамжийн бодлого хэрэгжүүлэхээр тусгасан Засгийн газар ч аль учраа олохгүй сандарч эхэллээ.

**Төгсгөл нь III нүүрт**




ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## МОНГОЛЫН ХҮНИЙ ИХ ЭМЧ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨВ

Н.БАТЗАЯА

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн хүний их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, гэрчилгээгээ хүлээн авах ёслолын үйл ажиллагаа өчигдөр АШУҮИС-ийн Соёлын төвд боллоо. Энэхүү ёслолын үйл ажиллагаанд АШУҮИС-ийн захирал Г.Батбаатар, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн дэд дарга Х.Батсайхан, Азийн хөгжлийн банкны дэргэдэх дээд боловсролын төсөл хэрэгжүүлэх нэгжийн дарга Т.Сувдмаа, Лаос улсын Элчин сайдын яамны дэд тэргүүн Вонфила болон тус сургуулийн багш, оюутнууд оролцсон.

**Төгсгөл нь XI нүүрт**

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2458.00 | 2470.00 | ФУНТ | 3018.00 | 3122.00 |
| ЕВРО | 2998.00 | 3101.00 | РУБЛЬ | 36.20 | 39.30 |
| ИЕН | 21.80 | 22.05 | ЮАНЬ | 355.00 | 358.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2460.00 | 2470.00 | ФУНТ | 3050.00 | 3132.00 |
| ЕВРО | 2600.00 | 2672.00 | РУБЛЬ | 36.62 | 39.42 |
| ИЕН | 21.72 | 22.34 | ЮАНЬ | 355.00 | 360.00 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхийлөгч Японы Элчин сайдтай уулзлаа

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Такэнори Шимизүг бүрэн эрхийнхээ хугацааг өндөрлүүлэн эх орондоо буцаж байгааг нь тохиолдуулан өнөөдөр хүлээн авч уулзав. Уулзалтын эхэнд Элчин сайд Такэнори Шимизү цаг гарган хүлээн авч уулзаж байгаад нь Монгол Улсын Ерөнхийлөгчид талархал илэрхийллээ. Тэрбээр Монгол Улсад нийтдээ таван жил хоёр сар ажиллажээ. Энэ хугацаанд хоёр улсын харилцаа өндөр түвшинд хүрсэн хэмээн үзэж байгаагаа Элчин сайд илэрхийлж, үүнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн оруулсан хувь нэмэр маш их байсан гэдгийг хэлэв.

Харин Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хариу хэлсэн үгэндээ "Таны хэлснээр хоёр орны харилцаа өндөр амжилтад хүрсэн гэдэгтэй би санал нэг байна. Үнэхээр хоёр орны харилцаа Монгол Улс нээлттэй нийгэмд шилжсэнээс хойш урьд өмнө төсөөлж байгаагүй сайн төвшинд хүрсэн. Хоёр ард түмний хоорондын харилцаа ч дээд төвшинд хүрсэн. Энэ үйл ажиллагаанд эрхэм Элчин сайд таны оруулсан хувь нэмэр асар их байгаа. Та бол гадаад харилцааны салбарт Монгол Улстай хамгийн удаан хамтарч ажилласан хүний нэг байх" гэв.Хоёр орны хоорондын шинэ хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөрийг бэлтгэж байгааг Элчин сайд уулзалтын үеэр мөн онцолж байлаа.

БАЙНГЫН ХОРОО



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Ж.БАТЗАНДАН: МҮОНРТ-ИЙН ДАРГААР МАН-ЫНХАН НЭГ НАМЧИРХСАН НӨХРИЙГ ТОМИЛНО

Ж.ОТГОН

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаанаар Монголын үндэсний олон нийтийн радио телевиз /МҮОНРТ/-д хийсэн шалгалтын дүнг сонсох, МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай, МҮОНРТ-ийн тухай хуулийг өөрчлөх эсэх, мөн тус газарт мэргэжлийн байгууллагын шалгалт оруулах эсэх асуудлыг хэлэлцэв. Хурлын эхэнд ажлын хэсгийн ахлагч Н.Цэрэнбат шалгалтын дүнг танилцуулсан юм. МҮОНРТ-д хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг мэргэжлийн байгууллагаар нарийвчлан шалгуулахаар болов. Өөрөөр хэлбэл, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Үндэсний аудитын газар, Сангийн яамны Төсвийн хяналт эрсдлийн удирдлагын газарт Байнгын хорооны тогтоолоор чиглэл өгч, илэрсэн зөрчлийг нарийвчлан шалгаад байнгын хороонд танилцуулахыг үүрэгдсэн юм. Үүний дараа МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэв. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Х.Чилаажавыг томилохыг дэмжсэн юм. Хуралдааны үеэр УИХ-ын гишүүн О.Баасанхүү "Танай МАН-ын пиарын зөвлөх байсан Н.Дэмбэрэл хэзээ халагдчихсан бэ. Энэ хуралдаанд ҮЗХ-ны дарга нар яагаад оролцсонгүй. Нэг талыг нь бариад яриад байх шиг санагдаад байна" хэмээн тодруулсан юм. Харин УИХ-ын гишүүн М.Оюунчимэг "Үндэсний зөвлөлийнхнийг хуралдаанд суулгахаар утсаар залгаж асуусан. Н.Энхмандах дарга боломжгүй гэсэн, нарийн бичгийн дарга нь өвчтэй, Ц.Оюундарь дарга чөлөө авсан байсан. Тэнд өнөөдөр эзэнгүй айл шиг байна. Үндэсний зөвлөл дотоод аудитын шалгалтыг гаргасан. Нийт уран бүтээлчдийн 70-80 хувь нь шаардлага гаргасан байсан. Шалгалтын аудитын дүнгээр хууль зөрчсөн зүйл их байсан. Энд хүний эрх ноцтой зөрчсөн байна. Хоёр ч хүн шүүхэд ханджээ. Буцааж ажилд нь авах шүүхийн шийдвэр гарсан байна" нэмэлт тайлбар хийлээ. УИХ-ын гишүүн Ж.Батзандан "ОНРТ-ийн хууль гэж байгаа. Энэ хуулиа өөрчлөх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол нэг нам гарч ирээд л намчирхсан нэг нөхрийг МҮОНРТ-ийн даргаар тавьдаг болсон байна. Ц.Оюундарийг аваад хаячихаж болно. Үүний дараа мөн л нэг намчирхсан нөхрийг Монгол Ардын намынхан томилно. Үүнийг мэдэж байна. Бидний тогтолцоо, байгаа байдал энэ. Дараагийн дарга нь Ц.Оюундариас дээрдэх зүйл байхгүй, улам ч дордоно. Хууль зөрчигдсөн гэж байна. Санхүүгийн зөрчлийг аудит, хөдөлмөрийн зөрчлийг хөдөлмөрийн байцаагч, татварын зөрчлийг татварын хяналтынхан тогтоох хэрэгтэй.

Асуудал хүндээ биш. Нэг удирдлага солигдохоор өлсгөлөн зарлаад байдаг байгууллага болчихжээ. МҮОНРТ-ийн хувьд нэг хэсэг нь дарга нарыг солих гээд, нөгөө талд хувьчилж авах гэсэн санаархал явж байна. Ажлын хэсгүүд 14 хоногийн дотор шуурхай ажиллажээ. Гэтэл Эрдэнэтийг шалгах ажлын хэсэг зургаан сарын дотор ажлаа хийж чадахгүй бүлэглэлийн гарт орчихоод явж байгаа. МАН 65 суудалтай хэрнээ цагдаа, тагнуулаа сольж чадахгүй байна" гэлээ. Ийнхүү МҮОНРТ-д адуит оруулахаар болж, Үндэсний зөвлөлийн гишүүдэд чиглэл өгөхөөр болов.

### Н.Учрал: УИХ-д инновацийг дэмжиж ажиллах лобби бүлгийг байгуулна

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос "Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн явц, цаашдын зорилго" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг Төрийн ордноо зохион байгууллаа. УИХ-аас 2012 оны тавдугаар сарын 22-ны өдөр Инновацийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд өнөөг хүртэл тус хуулинд дөрвөн удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоо байгаа боловч ажилладаггүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байдагт хэлэлцүүлэгт оролцогчид шүүмжлэлтэй хандаж байсан юм. Мөн эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаа энэ цаг үед шинжлэх ухааны салбарыг хөгжүүлж, эдийн засгийг солонгоруулах, инновацийн тогтолцоо, дэд бүтцийг бүрдүүлэх, гарааны компаниудыг дэмжих төрийн бодлого, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах асуудалд УИХ, Засгийн газар анхаарал хандуулж ажиллах шаардлага зүй ёсоор тулгараад байгааг хэлэлцүүлгийн үеэр хөндлөө. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн Н.Учрал "Манай улс дэлхийн хэмжээнд инновацийн хөгжлөөр хангалтгүй байна. Үүнийг хөгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Мөн энэ асуудлыг цэгцтэй, нэгдсэн зохион байгуулалтад оруулахад манлайлал хэрэгтэй байна. Иймд би Улсын Их Хуралд инновацийг дэмжиж ажиллах лобби бүлгийг байгуулна" гэлээ. Тэрбээр Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад асуулга тавиад байгаа юм. Энэ үеэр УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан "Өнөөдрийн зохион байгуулж байгаа хэлэлцүүлэг зөвхөн нэг удаа хийгээд зогсохгүй. Байнгын хорооноос жил бүр хийхээр төлөвлөсөн. Хуулийн хэрэгжилтийг сайжруулахын төлөө ажиллана" гэв. Ийнхүү УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос Инновацийн хуулийн хэрэгжилтийг шалгах Ажлын хэсгийг байгуулахаар болов. Түүнчлэн Засгийн газарт холбогдох дүрэм, журмуудыг боловсруулах, өмнө гарсан журмуудын уялдааг сайжруулах талаар чиглэл өгөхөөр тогтлоо.

### Аюултай хог хаягдлын байгууламж байгуулах газрыг сонгожээ

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар "Байгаль орчны төлөв байдлын 2013-2014 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай", "Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолуудын биелэлтийн талаархи Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролын мэдээллийг сонссон юм. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол мэдээлэлдээ байнгын хорооны 2015 оны тавдугаар сарын 06-ны өдрийн "Байгаль орчны төлөв байдлын 2013-2014 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 05 дугаар тогтоолын хүрээнд найман заалт бүхий үүрэг даалгаврыг БОАЖЯ-д өгсөн. Байгаль орчны төлөв байдлын тайланг УИХ-аар хэлэлцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Байгаль орчныг хамгаалах тухай хуульд "Засгийн газар байгаль орчны төлөв байдлын тайланг хоёр жил тутамд нэг удаа УИХ-ын хаврын чуулганд өргөн мэдүүлэх" талаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна. Цөлжилтийг бууруулах, гадаргын усны хомсдол, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн төслийн саналыг боловсруулан хандивлагч орон, олон улсын байгууллагуудад тавьсны үр дүнд тодорхой төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус яам нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Нийслэлийн өмч, газрын харилцааны албаны төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг 2016 онд байгуулж, аюултай хог хаягдлын байгууламж байгуулах газрыг сонгон, уг газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байгаа аж. Салбарын сайд мэдээлэлдээ байгалийн нөөц ашигласны төлбөр тухай хуулийн дагуу 2013-2015 онд жилд дунджаар 105.8 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрсөн. Уг хуулийн 18.1-д байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 15-85, түүнээс дээш хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар заасны дагуу гүйцэтгэлийг тооцоход сүүлийн гурван жилд хуулийн хэрэгжилт 40 орчим хувьтай байгааг онцолсон юм.

ЗАСГИЙН ГАЗАР

# ШАТАХУУНЫ ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫГ БУУРУУЛНА

Сүүлийн үед ам.доллартай харьцах төгрөгийн ханш суларсантай холбогдуулан бензин, шатахууны үнэ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч буй. Энэ хүрээнд аравдугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа "Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг тонн тутамд 240 мянган төгрөгөөр бууруулж, автобензинд тонн тутамд 260 мянга, дизелийн түлшинд тонн тутамд 280 мянган төгрөг болгосон юм.Сүүлийн үед газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ 30-33 ам.доллараар буурч байгаа сайн талтай ч, долларын ханшийн өсөлт нь нефть импортлогч компаниуд санхүүгийн алдагдалтай ажиллах, зах зээл дээр жижиглэнгийн үнэ нэмэгдэх шалтгаан болж байгаа юм. Иймд Засгийн газрын өчигдрийн хуралдаанаар автобензин, дизелийн түлшинд ногдуулдаг онцгой албан татварын хэмжээг төрөл тус бүрт дахин тонн тутамд 100 мянган төгрөгөөр бууруулах тогтоол баталлаа. Ингэснээр онцгой албан татварын хэмжээг автобензинд тонн тутамд 160 мянган төгрөг, дизелийн түлшинд 180 мянган төгрөг болголоо.

### Түрээсийн орон сууц хөтөлбөрт өөрчлөлт оруулав

"Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд 50 ам.метр талбайтай орон сууцыг төрийн өмчийн орон сууцны санд шилжүүлж байсныг 70 ам.метр хүртэл хэмээн өөрчлөхөөр Засгийн газрын хуралдаанаас шийдвэрлэлээ. Ипотекийн урьдчилгаа 30 хувийг бэлнээр төлж, банкны зээлийн шалгуур хангах иргэдийн тоо багасч байгаагаас "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын захиалгаар орон нутагт барьсан 70 ам.метр хүртэл талбайтай орон сууцнууд борлогдохгүй байна. Иймээс эдгээр орон сууцыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх хүсэлтээ аймгийн Засаг дарга нар Засгийн газарт ирүүлж байсан юм. Үүнийг үндэслэн "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын захиалгаар Улаанбаатар хот болон Дархан-Уул, Сэлэнгэ, Ховд, Увс, Хэнтий зэрэг орон нутагт баригдсан 70 м2 хүртэл талбайтай 360 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүллээ. Дээрх 360 айлын орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээлийн төлбөрт шаардагдах 30 тэрбум 286 сая төгрөгийг хянаж тодотгон улсын төсөвт үе шаттай тусгаж байхыг холбогдох сайд нарт даалгав. Зээлийн төлбөрөө бүрэн төлж барагдуулах хүртэлх хугацаанд зээлийн хүүгийн төлбөрийг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэн 360 айлын орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэхээр боллоо.Одоогоор 1000 гаруй өрхийг төрийн өмчийн түрээсийн орон сууцанд хамруулах боломжтой байгаа нь хүсэлт гаргасан иргэдийн 37 орчим хувь юм.

### Залуучуудын тухай хуультай болно

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн баталж, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хуульзүй, дотоод хэргийн сайд нарт даалгалаа. Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу салбарын яамнаас боловсруулснаар 16-40 насны залуучууд анх удаа бие даасан хуультай болох юм. Статистикаас үзвэл 2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт хүн амын 42.9 хувийг 16-40 насны залуучууд эзэлдэг байна.

Уг хуулийг батлансны дараа Засгийн газраас "Залуучуудын хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, залуучуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ гэж Засгийн газар үзэж байгаа юм. Судалгаанаас үзэхэд, залуу 10 өрх тутмын нэг нь түрээсийн байранд амьдардаг бөгөөд залуучуудын хөгжлийг дэмжих хуулийг батлаcнаар залуу гэр бүлүүд хөнгөлөлттэй үнээр орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх эрхзүйн орчин бүрдэх юм.

ШАР МЭДЭЭ

## Г.Батхүү намын даргын сунгаанд өнөө л бохир аргаараа...

АН-ын даргын сунгаанд албан ёсоор оролцохоо мэдэгдсэн хүмүүсийн нэрсийн жагсаалт нэлээд урт болоод байгаа. Тэгвэл намын даргын суудалд улайран дайрагч нэгэн шинэ хүн гараад иржээ. Тэр хүн бол АПУ-гийн гэх тодотголтой Г.Батхүү. Улайран гэсний учир нь тэрбээр дарга болохын тулд Ардчилсан намын үүрийн дарга нарын холбоог байгуулж, өөрөө тэргүүнээр нь сонгогдчихсон ажиллаж эхэлсэн байна. Намын даргын сунгаанд оролцоно гэх эрхмүүд хэвлэл мэдээллээр ганц хоёр удаа яриа өгөхөөс хэтрэхгүй байгаа. Харин Г.Батхүүгийн хувьд шууд л тэмцлийн "хурц" хэлбэрт шилжсэн бололтой. Ёстой л мөнгөтэй хүн гэдэг утгаараа өнөө л бохир аргаараа буюу бүхнийг мөнгөөр үнэлж, шийдэхээр шунаж эхэлжээ. Албан бус эх сурвалжийн мэдээлж буйгаар тэрбээр "С.Эрдэнийг аврахын тулд АН-ын бүлэг тарах уу" гэх мэдээллийг төлбөртэй түгээж эхэлсэн сурагтай. Мөн намын үүрийн дарга нараа өөрийн талдаа оруулж чадсан, Ардчилсан залуучуудын холбоогоо 100 сая төгрөгөөр авчихсан гээд далд байдлаар даргын эрх мэдлийг авахын төлөө үзэж тарж байгаа гэнэ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

## Ядуурлыг бууруулах төсөл буюу сүлжээний луйвар

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Бүр тусдаа хаалттай групптэй, тэндээ 110 гаруй мянган гишүүнтэй болчихсон. Өнөөдүүл нь дор бүрнээ хүн ухуулаад л, шинэ жилээс өмнө 8000 ам.долларын цалин авах уу ч гэж байх шиг. Өнөөхийг хүмүүс сонирхож байгаа гэж жигтэйхэн. 272 мянган төгрөгөөр элсч, найман хүн нэг баг болоод, дараа нь хоёр сая 292 мянган төгрөг авна ч гэж байх шиг. Тэр нь вип хөтөлбөр гэж байгаа. Энэ мэтээр хамгийн ихдээ хоёр сая 176 мянган төгрөг оруулаад дараа нь 18 сая 336 мянган төгрөг авна гэж байгаа юм. Ёстой сайхан сонсогдож байгаа биз. Мэдээж дотроо тодорхой дүрэм журам гэж байгаа байх. Гэхдээ л эцсийн дүндээ энэ чинь сүлжээ. Сүлжээний бизнес прамид тогтолцоотой байдаг. Хамгийн гол нь энэ төслийг луйвар гэдгийг ЦЕГ-аас анхааруулчихаад байгаа. Гэтэл манайхан хашрахгүй, нэгдэж орсоор байна.

Бүр төрийн том байгууллагууд хүртэл бөөнөөрөө элсч орсон мэдээ хүртэл байна. Дарга нь пирамидын дээр суугаад, ажилчдаа дороо элсүүлсэн юм байх аа. Хэрвээ үнэхээр ашиг олдог бол дарга нь л хэдэн төгрөг олж авах байх. Харин прамидын сууринд байгаа хүмүүс бол 100, 200 мянган төгрөгөө өгөөд л алдана. Мөнгөө эргүүлж авах боломж байхгүй. Цалин авна гэвэл хүн элсүүлэх шаардлагатай болно. Чадахгүй бол тэгээд л хохироод дуусч байгаа юм. Мэдээж сүлжээний бизнест өөрөө сайн дураараа орсон учраас луйвар гэж үзэхгүй. Манайд уг нь сүлжээний бизнесийг хориглосон хууль журам байдаг юм билээ. Гэвч хэрэгжиж байгаа юм алга. Хэрэгжүүлэхээр ажиллах газар ч байхгүй. Үүнийг нь луйварчид мэддэг учраас янз бүрийн аргаар шинэ сүлжээ эхлүүлсээр, хүмүүсийн мөнгийг хуурч авсаар л байгаа байх.

Мэдээж сүлжээний бизнесийг эхлүүлсэн хэдэн нөхдүүд багагүй мөнгө олж байгаа болов уу. Тэгвэл шинээр элсэгчид бол юу ч олж долоохгүй шүү дээ. Тэгээд ядаж байхад бэлэн мөнгөө оруулна. Бусад сүлжээ шиг ядаж бүтээгдэхүүн аваад үлдэнэ гэсэн юм байхгүй шүү дээ. Тийм болохоор бүр ч их хохироод байгаа юм. Одоо бүр сүүлдээ төрийн байгууллагынхан хүртэл даргынхаа араас элсч байна. Энэ бүхнийг холбогдох газрууд нь анхаармаар байгаа юм. Тэр төрийн байгууллагынх нь нэрийг биччихээр манай тэгээгүй, нэр төрд халдлаа, шүүхэд өгнө энэ тэр гэнэ л дээ. Угаас тэгж дайрдаг болсон хойно. Гэхдээ хамгийн эмгэнэлтэй нь сүлжээнд бүр төрийн байгууллагатайгаа уусч эхэллээ шүү дээ. Тиймээс л энэ элдэв сүлжээний луйвраас бүгд сэрэмжилж, анхаармаар байна. Холбогдох хуулийн байгууллагууд хүртэл яаралтай арга хэмжээ авч, ард иргэдээ сэрэмжлүүлээч ээ. Одоо бүр сүүлдээ математикийн хэдэн багш нийлээд сүлжээний бизнес бий болгож байна гэнэ, цаана чинь. Бэлэн мөнгөтэй болоод, амархан баяжих гэсэн хүмүүсийн гэнэн хүсэл дээр дөрөөлөх аргаа олчихсон байхгүй юу.

# Монголын эдийн засагт МӨДДӨӨ НАР ТУСАХГҮЙ НЬ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Эдийн засаг ирэх онд өөдлөхгүй нь гэх дүгнэлтийг олон янзаар тайлбарлаж болно. Хамгийн нэгдүгээрт, бид ирэх оны төсвөө хэрхэн баталсан бэ гэдэг асуудал. Төв банкны оруулж ирсэн Мөнгөний бодлоготойгоо төсөв нь уялдаж чадсан эсэх, өмнөх Төв банкны Ерөнхийлөгч Н.Золжаргалын хэрэгжүүлж байсан "Шинэ тэнцвэр" буюу төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг 2017 оны төсөвтэй хэрхэн уялдуулж өгсөн бэ гэдгээс ихээхэн зүйл шалтгаална. Харамсалтай нь 2017 оны төсөв хүсэн хүлээж байсан шиг алдагдалгүй, орлого зарлагаа зөв тооцоолсон, төсвийн үрэлгэн зардлыг хумисан төсөв байж чадаагүй. Зөвхөн халамжийн бодлогод л 500 тэрбумыг зарцуулахаар оруулж ирсэн атлаа эх үүсвэрээ хэрхэн олохыг төсөвт тусгасангүй. Тиймдээ ч ирэх онд ихэнх халамжийн бодлого нь хэрэгжихгүй гэдгийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн мэдэгдсэн билээ. Ажилгүйдлийн төвшинг бууруулах гэхээс илүү аж ахуйн нэгжийг торгох төсөв бүрдүүлэх заалт тусгаж, улсын төсөвт хамгийн их татаас, татвар төлдөг хүнс, хөдөө аж ахуйн салбараа бор зүрхээрээ зүтгэ хэмээн зөнгөөр нь орхив. Жижиг, дунд үйлдвэрлэл, хүнд үйлдвэрлэл зэрэг 2012 онд босгосон Чингис бондын санхүүжилтээр хөл дээрээ зогсч эхэлж байсан салбаруудыг ор тас мартаж, өөрсдийнхөө эргэн төлөлтөөс санхүүж хэмээн "нясалж" орхисноор ирэх онд бид хаанаас

...Юутай ч Монголын эдийн засагт ирэх оныг давах, цалингаа тавих, халамжаа өгөх амь тариа болоод байсан дөрвөн тэрбум ам.доллар салхинд хийсч орхилоо. Ингэснээр ам.долларын ханш дахиад л савалгаатай байдалд орох нь. Олон улсын валютын сангийнхан "Стэнд бай" хөтөлбөрт орох саналыг хүлээж авах эсэхээс ихээхэн зүйл хамаарах нөхцөл байдал үүсчихлээ...

мөнгө босгож, хэрхэн амьдрах вэ гэсэн асуулт хариулт хүлээсэн хэвээр байгаа юм. Ажилгүйдэл ч ирэх онд эрчээ авах нь тодорхой болж байна. Албан байгууллагууд ажилчдаа цомхотгох давалгааг Төрийн банк эхлүүлж, 230 гаруй ажилчдаа цомхотголд оруулахаар болсон гэх мэдээлэл явж байна. Цомхотгол цаашдаа ч эрчимтэй өрнөнө. Монгол Улс ирэх онд хаанаас, хэрхэн мөнгө олох нь тодорхой бус байгаа иим нөхцөлд тэсч үлдэх газар тун ч цөөхөн байх биз.

### Далай ламын айлчлал ам.долларын ханшид нөлөөлөв үү

Хоёрдугаар том шалтгаан бол яах аргагүй энэ юм. Бурхан шашинтны тэргүүний айлчлал ямар утгаараа ам.доллартай уялдаж орхисныг гайхаж асуух хүн олон байгаа. Тэгвэл энэ айлчлалын хүрээнд БНХАУ-аас зээлэхээр тохирсон дөрвөн тэрбум ам.долларын зээлийн яриа хэлцэл цуцлагдлаа. Төрийн олон айлчлалууд тодорхойгүй байдалд орсон. УИХ-ын даргын ах дүүгийндээ очиж байгаа аятай албан нэртэй албан бусаар хийсэн долоо хоногийн айлчлалын дүнд бидурдхөршөөсөө дөрвөн тэрбум ам.доллар зээлэх тохироонд хүрээд байсан юм билээ. Гэвч өмнөд хөршийнхөө хамгийн дургүй зочдынх нь нэгийг урьснаар тэднийг гомдоож орхижээ. Далай ламыг хэн урьсан талаар улс төрийн хүрээнд ч маргаан гараад амжлаа. Төрийн тэргүүн урьснаар биднийг, Монголын эдийн засгийг хорлолоо гэх мэдэгдлийг Ардын намын нөлөө бүхий улстөрчид хэлж байгаа бол, харин эсрэгээрээ виз өгөх эрх мэдэл нь хэний Засгийн газарт байгаа вэ гэдэг асуудал ч хөндөгдөж буй гэх. Юутай ч Монголын эдийн засагт ирэх оныг давах, цалингаа тавих, халамжаа өгөх амь тариа болоод байсан дөрвөн тэрбум ам.доллар салхинд хийсч орхилоо. Ингэснээр ам.долларын ханш дахиад л савалгаатай байдалд орох нь. Олон улсын валютын сангийнхан "Стэнд бай" хөтөлбөрт орох саналыг хүлээж авах эсэхээс ихээхэн зүйл хамаарах нөхцөл байдал үүсчихлээ. Зарим эх сурвалжуудын мэдэгдэж буйгаар "Стэнд бай" хөтөлбөрт орох асуудлыг түр хойшлуулж, тун ч өргөн хүрээний хөтөлбөр эхлүүлэхээр Төв банк бэлтгэж буй гэх яриа гарчээ. Валют зээлэх эсэхээс үл хамаарч ирэх оны эдийн засаг туйлын хүнд, хэцүү замаар урагшлах нь тодорхой байна. Төв банкны валютын нөөц хамгийн сүүлд авсан мэдээллээр нэг тэрбум байгаа юм. 2016 оныг дуустал энэ нөөц амь тариа болж, ханшаа хөөрөгдчихөлгүй дарж байхад хангалттай хүрэлцэх ч, он гарсны дараа хэрхэх вэ гэдэг асуулт зүй ёсоор яригдана. 2017 онд бид Чингис бондын эхний эргэн төлөлтийг хийх учиртай. Монгол Улсын зээлжих зэрэглэл "С" үнэлгээ рүү орж, олон улсын хөрөнгийн биржид бондын хувьцаа уналттай байгааг нуух аргагүй болсон. Эргэн төлөлтийн мөнгийг хаанаас олох нь өнөөдрийг хүртэл тодорхой бус явж буй. Эрдэнэт, Хөгжлийн банк зэрэг гайгүй гэсэн аж ахуйн нэгж, төрийн өмчит компаниуд бүгд өрийн сүлжээнд баригдаж, хэдэн тэрбумаар тоологдох их өрийн асуудал улстөрчдийн талцаж хэрэлдэх сэдэв болоод байна. Хувьчлалтай холбоотой төгрөгийн ханш унасан гэдгийг ч эдийн засагчид дуу нэгтэй хүлээн зөвшөөрчихсөн. Авлигатай тэмцэх газарт ар араасаа дуудагдаж байгаа тэднээс ихийг хүлээх шаардлагагүй юм.

### Монголын нүүрс хэзээ үнэд орох вэ

Энэ мэтээр монголын эдийн засагт гялтайх сайхан мэдээ ширхэг ч алга. Тавантолгойн баруун, зүүн цанхи хоёр зэрэг ажиллаж эхэлсэн сайхан мэдээ дуулдсан ч тонн нүүрсээ нэг кг байцаанаас ч хямдхан хилээр гаргасан хэвээр байна, бид. Дэлхийн зах зээлд тонн нүүрсний үнэ 100 ам.долларт хүрчихээд байхад, манайх хамгийн хямдаар, дөнгөн данган 50 ам.доллар хүргэж байгааг сайн мэдээ гэж хэлэхгүй болов уу. Чалькод төлөх өрийг сар шинийн өмнөхөн дуусгана гэдгийг Уул уурхайн яамнаас мэдэгдсэн ч баталгаатай хугацаа биш. Тиймдээ ч өдөрт хэдэн зуун тонноор нь нүүрсээ үнэгүй шахам өмнөд хөрш рүү өрөндөө зөөсөн хэвээр ирэх оныг дуусгаж ч магадгүй. Төсвийн дийлэнх хувийг бүрдүүлэх учиртай Монголын нүүрс хэзээ үнэд орохыг таамж мэдэх арга одоогоор алга. Монголын эдийн засагт жин дарах найман хувийн хүүтэй ипотекийн зээлд ирэх онд мөнгө төсөвлөөгүй. Өөрөөр хэлбэл, банкууд өмнөх онуудад өгсөн зээлийнхээ эргэн төлөлтөөс буцааж зээл олгох учиртай. Гэвч, ипотекийн найман хувийн зээл хэвийн үргэлжлэх эсэхийг хэлэхэд эрт байгаа юм. Банкууд эргэн төлөлт хэвийн байгаа ч өнөөдрийн байдлаар арилжааны банкууд зээл олгохгүй хэвээр байгаа аж. Төрийн банк ипотекийн зээлийг үргэлжлүүлж, сард 100 орхөд зээл олгож байсан ч мөн л тодорхойгүй хугацаагаар зогсоосон сурагтай. Ханшийн өсөлтийг хянаж, төгрөгийн сулралын эсрэг тууштай тэмцэх учиртайТөв банкны Ерөнхийлөгч нь хаана юу хийж явааг мэдэх юм алга.Төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, цалин пүнлүүгээ асуудалгүй тавихад анхаарах учиртай Сангийн сайд маань валютын ханш дээш доош болохыг анхааралтай ажиглаж суусаар гурван сарыг үдлээ. Засгийн газартай энэ тухай яриад ч хэрэггүй. Цас мөсөө хэнээр цэвэрлүүлэх тухай "жижиг" асуудалтай зууралдаж суугаа Ерөнхий сайдаас ханшийн өсөлт, эдийн засгийн нарийн зүйлийг асууж шалгаах нь цаг гарзадсан хэрэг болно. УИХ ч ялгаагүй. Өмнөх Засгийн газар өр тавьснаас болж бид иим байдалд орлоо хэмээн өмнөхөө зүхэж занасаар эхний 100 хоногоо өнгөрүүллээ. Цаашид Монголын эдийн засгийг аврах дорвитой шийдвэр гаргаж чадахгүй, энэ хэвээр зээлд найдаж, хойдох, урдах руугаа буруугаа чихсээр суувал ам.долларын ханш 5000 төгрөгтэй тэнцэх нь цаг хугацааны л асуудал болоод байгааг сануулах нь илүүц биз. Жилийн жилд яригдаж байгаа уул уурхайгаас хамааралтай эдийн засгаа хэрхэн аврах вэ, Ж.Эрдэнэбат Ерөнхий сайд аа. Том төсөл хөтөлбөрүүд хэзээ хөдөлж, тэрбум тэрбумаар зээл тавихаа болих вэ, Б.Чойжилсүрэн, Ц.Дашдорж нарын сайдууд аа. Ханш хэрхэн өсөх нь маньд хамаагүй хэмээн буруу шийдвэрээс зугтаж, бүгэж суусаар байх уу, Н.Баяртсайхан Ерөнхийлөгч өө. Эдийн засаг элгээрээ мөлхөж байгаа бурууг бид хэнээс эрэх вэ. Хувь хувьсгалын байгууллага хаалга барьж дампуурч л байг уу. Өмнөх Засгийн газрын буруу шийдвэр өмнөхтэйгээ л үлдэнэ. Одоогийн цаг хугацаа одоогоороо л байх учиртай. Тиймээс бусдаас бурууг эрж суухын оронд бодлогын дорвитой шийдвэр гаргаач гэж ард түмэн хүсч байна. Ажлаа хийж чадахгүй бол чаддаг нэгэнд нь өгөх сонголт бас байдгийг сануулъя.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# УЛС ТӨР & ЭДИЙН ЗАСАГ

Н.ПУНЦАГБОЛД

*Монголбанкаас өчигдөр хэвлэл мэдээллийнхэнд цаг үеийн асуудлаар мэдээллүүдийг өглөө. Тэр дундаа 2016 оны аравдугаар сарын орон сууцны үнийн индекс болоод өнгөрөгч сарын статистикийн тоймыг мэдээлсэн юм. Орон сууцны үнийн индексийн мэдээллийг “Тэнхлэг зууч” компанийн гүйцэтгэх захирал Д.Должинсүрэн өглөө.*





*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## Дефляци ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА

### Шинэ орон сууцны дундаж үнэ 2.03 сая төгрөг байна

Монгол банкны захиалгаар Үл хөдлөх хөрөнгийн “Тэнхлэг зууч” компани хараат бусаар “Орон сууцны үнийн индекс”-ийн судалгааг хийсэн аж. ОСҮИ-ийг Хедоник регрессийн аргаар тооцоолсон бөгөөд энэхүү тооцоололд тухайн сард Улаанбаатар хотод борлуулагдахаар зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин нийт 4891 орон сууцны мэдээллийг хамруулжээ. Судалгаагаар өнгөрсөн аравдугаар сард Орон сууцны үнийн ерөнхий индекс 1.1 хувьтай гарсан байна. Энэ нь өмнөх сараас 0.16 хувиар буурсан үр дүн аж. Ерөнхий индексийг эхэн үетэй харьцуулахад 4.1, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 5.6 хувиар буурсан байна. Харин үнийн индексийн үзүүлэлтийг шинэ, хуучин орон сууцаар ангилж үзвэл шинийнх нь 14.4 хувьтай гарсан аж. Энэ нь өмнөх сараас төдийлөн өөрчлөгдсөнгүй. Харин оны эхэн үетэй харьцуулахад, 3.9 хувь, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.7 хувиар буурсан байгаа юм байна. Тэгвэл хуучин орон сууцны үнийн индекс -7.3 хувьтай гарсан байна. Энэ нь өмнөх сараас 0.3 хувиар буурсан бол оны эхэн үетэй харьцуулахад 5.9, өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.5 хувиар буурчээ. Харин 2016 оны аравдугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 0.2, өнгөрсөн оны мөн үеэс 5.6 хувиар буурчээ. Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ орон сууцны үнэ өссөн ч хуучин орон сууцны үнэ бага зэрэг буурсан нь үнийн индекс буурахад нөлөөлсөн юм байна. Тэгвэл шинэ орон сууцны ам.метрийн дундаж үнэ энэ оны аравдугаар сарын байдлаар хоёр сая 38 мянган төгрөг байгаа аж. Энэ нь өмнөх сараас 0.1 хувиар өссөн үзүүлэлт бол өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.4 хувиар буурчээ. Харин Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны ам.метрийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгинохайрханд хамгийн бага байгаа аж. Тодорхой хэлбэл, Сонгинохайрхан дүүрэгт шинэ орон сууцны ам.метрийн дундаж үнэ 1.56 сая төгрөг байна. Тэгвэл хуучин хоёр өрөө орон сууцны үнэ энэ оны аравдугаар сарын байдлаар 75.8 сая болж, өмнөх сараас 0.8, өмнөх оны мөн үеийнхээс 1.2 хувиар буурчээ. 2015 оны аравдугаар сард хуучны хоёр өрөө байрны үнэ 87 сая төгрөг байсан байна.

### Гурван сар дараалж дифляцитай гарлаа

Улаанбаатар хотын орон сууцны үнийн индексийн аравдугаар сарын судалгааны үр дүнг танилцуулсны дараа Монголбанкны Олон нийтийн боловсрол мэдээллийн төвийн ахлах эдийн засагч Б.Түмэнцэнгэл аравдугаар сарын статистикийн тоймыг мэдээлсэн юм. Тэр дундаас хамгийн их анхаарал татсан мэдээлэл нь Улаанбаатар хотын инфляци байлаа. Улаанбаатар хотын жилийн инфляци аравдугаар сарын 31-ний байдлаар -0.8 хувьтай гарчээ. Ингэснээр энэ оны найм, ес, аравдугаар сард инфляци хасах хувьтай гарч, дифляци үргэлжилсээр байна. Наймдугаар сард Улаанбаатар хотын жилийн инфляци -0.6 хувь байсан бол есдүгээр сард -0.7, аравдугаар сард -0.8 болж буурсаар байна. Анх инфляци хасах руу ороход амтай болгон эдийн засаг сүйрлээ гэж хашгирч байсан бол одоо дөжирчээ. Жилийн инфляци -0.8 хувьтай гарахад мах болоод хүнсний бүтээгдэхүүний үнэ нөлөөлсөн байна. Тэр дундаа хүнсний ногоо. Тодруулбал, хүнсний ногооны бүлгийн үнэ -0.5, мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ -0.4 нэгжээр буурсан юм байна. Түүнээс гадна банкны секторын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэн байна. Нийт чанаргүй зээл 1.13 тэрбум төгрөг хүрч, нийт зээлийн 9.1 хувийг эзэлж эхэлжээ. Энэ нь өнгөрсөн есдүгээр сараас 0.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Харин чанаргүй зээлийн хэмжээ энэ оны хоёрдугаар улирлаас даруй 100 гаруй сая төгрөгөөр өсчээ. Чанаргүй зээлийн 32 хувийг уул уурхайн салбар эзэлж байгаа бол барилга найм, худалдаа 20, боловсруулах салбар 13, бусад салбар 22 хувийг эзэлж байгаа ажээ.

МЭДЭЭЛЭЛ

## Эрдэнэт үйлдвэр нийт ажилчдаа урамшууллаа

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захирлын 2016 оны 11 сарын 29-ний өдрийн А/746 тоот тушаалаар үйлдвэрийн бүх ажилчдыг урамшуулсан байна. 2016 оны эхний 10 сард компанийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, хямралын эсрэг арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, тонн цэвэр зэсийн өөрийн өртгийг олон улсын зэсийн уурхайн компаниудын дундаж өөрийн өртгийн хэмжээнд хүртэл /3974 ам.доллар/ бууруулахад нийт компанийн ажилтнуудын оруулсан бодит хувь нэмэр, идэвх оролцоог өндрөөр үнэлэн цаашид бүтцийн нэгжүүд болон ажилтан бүрийн хүчин чармайлтыг нэмэгдүүлэх зорилгоор ажилчдаа урамшууллжээ. Ингэхдээ тус компанийн үндсэн ажилтан тус бүрийг 500, гэрээт байгууллагуудын ажилтан тус бүрийг 300 мянган төгрөгөөр урамшууллжээ. Түүнээс гадна Компанийн техникийн найдвартай байдлыг хангах, үйлдвэрлэлийн технологийн өргөтгөл, шинэчлэл, хүчин чадлыг сайжруулах, геологийн эрэл хайгуул хийж, ордын нөөцийг нэмэгдүүлэхэд идэвх зүтгэл, санаачилгатай ажилласан хүмүүсийг тусгайлан шагнасан байна.

Тодруулбал, Эрчим хүчний 1020 мм-ийн диаметртэй эргэлтийн усны гуравдугаар шугам, мөн эргэлтийн усны 2х10000 м/кубын усан санг амжилттай ашиглалтад оруулсан Эрчим хүчний цехийн дарга Г.Батмөнх, Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйд долдугаар насосыг өөрсдийн хүчээр шинээр суурилуулж, ашиглалтад оруулсан хаягдлын далангаас шүүрч буй усыг цуглуулж авах, эргүүлэн үйлдвэрлэлд ашиглах зориулалттай шүүрүүлэх сувгийг цэвэрлэх ажлыг амжилттай зохион байгуулж удирдсан Баяжуулах үйлдвэрийн дарга Д.Эрдэнэцогт тэргүүтэй долоон хүнийг сарын цалингаар шагнаж, урамшуулсан байна.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

## Л.ЭНХ-АМГАЛАН: БҮРЭН ЭРХЭЭСЭЭ ТАТГАЛЗАЖ, ШАЛГУУЛАХАД БЭЛЭН БАЙНА



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Ж.МЯГМАР

*Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголбанкны төлөөлөл бүхий нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Хөгжлийн банк байгуулагдсанаас хойшхи үйл ажиллагаанд шалгалт хийж дууссан. Тэгвэл энэхүү ажлын хэсэг санал дүгнэлтээ Засгийн газрын хуралдаанд танилцуулаад байгаа. Улмаар байнгын хороо болон чуулганы хуралдаанаар шалгалтын үр дүнг авч хэлэлцэхээр болсон. Тиймээс ч сүүлийн хэдэн өдөр Хөгжлийн банкаар дамжиж олгогдсон төсөл хөтөлбөрийн санхүүжилт болоод зээлийн асуудал яригдаж эхлээд байгаа. Энэ хүрээнд УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн хувь эзэмшдэг 3-4 компани нэлээд их хэмжээний мөнгө Хөгжлийн банкнаас зээлсэн гэх мэдээлэл цацагдаад байгаа. Тиймээс эрхэм гишүүн энэ талаар хэвлэлийнхэнд мэдээлэл хийлээ. Тэрбээр Хөгжлийн банкнаас гарсан зээлийн 60 хувь нь МАН-ын гишүүдтэй холбоотой аж ахуй нэгж байдаг гэсэн мэдээллийг үгүйсгэсэн юм.*

**-АН-ын бүлгээс Хөгжлийн банкнаас гарсан зээлийн 60 хувь нь МАН-ын гишүүдтэй холбоотой гэх мэдээлэл өгөөд байгаа. Энэ талаар мэдээлэл өгөөч?**

-АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ, дэд дарга Д.Пүрэвдорж нар үндэслэлгүй, нэр төрд халдсан мэдээлэл хийсэн. Тодруулбал, Хөгжлийн банкыг өмнө нь шалгаж байсан Л.Энх-Амгалан, Н.Номтойбаяр, Ц.Гарамжав болон МАН-ын нэр бүхий гишүүдийн компаниуд нийт зээлийн 60 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг авсан байна гэсэн. Миний хувьцаа эзэмшдэг компаниуд Хөгжлийн банкнаас нэг ч төгрөгийн зээл аваагүйг хариуцлагатайгаар мэдэгдье. Тиймээс УИХ-ын Халдашгүй байдлын дэд хорооны дарга Ц.Нямдорж, УИХ-ын Ёс зүйн дэд хорооны дарга Д.Лүндээжанцан нарт хандаж, УИХ-ын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхээсээ татгалзаж, хууль хяналтын байгууллагад шалгуулахад бэлэн байна гэсэн хүсэлт гаргалаа. Хэрэв миний бие хууль зөрчсөн гэж тогтоогдвол би УИХ-ын гишүүний бүрэн эрхээсээ татгалзахад бэлэн байна.

**-Өнгөрсөн парламентын үедАрдчилсан нам, МАН-ын гишүүд Хөгжлийн банкинд шалгалт хийсэн. Тухайн үед ажлын хэсгийн ахлагчаар та ажилласан. Та бүхний гаргасан дүгнэлтийг УИХ-аар хэлэлцээгүй шүү дээ. Яагаад?**

-Өмнөх дүгнэлтээр Хөгжлийн банк олон хуулийг зөрчсөн, УИХ, Засгийн газраар батлуулаагүй олон зуун тэрбумын төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн гэдэг нь баримтаар нотлогдсон. Хоёрдугаарт, гэрээ байгуулаад, гүйцэтгэлээ хийгээд мөнгөө авахдаа төсөвт өртгийг нь 3-4 дахин нэмж авсан олон компани байна. Гуравдугаарт, ямар нэг тендергүй төсөл, хөтөлбөрүүд шалгаруулж байсан. Тиймээс энэ асуудлыг хуулийн байгууллагад мэдэгдсэн. Одоогоор хэрэг үүсгээд шалгаж байна.

**-Хөгжлийн банкнаас гарсан нийт зээлийн эргэн төлөлт нь ямар төвшинд байна вэ?**

-2000 гаруй аж ахуй нэгжид арилжааны шинжтэй зээл олгосон юм байна. Гэхдээ Хөгжлийн банкаар зээл олгохдоо Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гаргасан байна. Энэ нь нийт төслийн санхүүжилтэд шаардлагатай байгаа зээлийн 2/3 хувийг тухайн компани гаргасан байх ёстой. Үлдсэн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас олгоно гэсэн зөвлөмж гаргасан. Гэтэл харамсалтай нь өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкнаас олгосон зээлүүд Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг зөрчсөн буюу 100 хувь төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон байна. Тиймээс би АТГ-т өнөөдөр дахин хүсэлт гаргаж, 2012 оноос хойш миний хөрөнгө орлогын мэдүүлэгт мэдүүлсэн компаниудын аль нь хэдэн төгрөгийн зээл авсан бэ, Хөгжлийн банканд шалгалт хийх ажлын хэсгийг ахалж ажиллахдаа УИХ-ын гишүүнийхээ бүрэн эрхийг ашиглаж, хууль бусаар зээл авсан байна уу гэдгийг тогтоож өгөхийг хүснэ. АТГ дүгнэлт гаргасны дараа Ёс зүйн дэд хороо, Халдашгүй байдлын дэд хороо хуралдаж дүгнэлтээ гаргах байх.



# ОНЦЛОХ ХУУДАС

## Õýí íü õýí áý?



# САЛБАРТАА ГОЛОГДОХГҮЙ САЙД

О.УЯНГА

"Монголын мэдээ" сонин "Мэргэжлийн" Засгийн газрын сайдуудыг "Хэн нь, хэн бэ" булангаараа онцолж байгаа билээ. Энэ удаад Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогтыг онцолж байна.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

> ...Мөн хилийн хориг тавигдсан дотоод, гадаадын 6000 орчим иргэний асуудлыг судалж үзээд холбогдох эрх бүхий байгууллагаас Монгол Улсын 298 иргэн, гадаадын 21 нийтдээ 319 иргэнд хориг тавьсан асуудлыг цуцалсан. Түүнээс гадна хуулиас давсан 100 гаруй дүрэм журам, тушаал шийдвэрийг цуцалсан. Дээрээс нь Архивын Ерөнхий газар иргэдэд архивын лавлагаа, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх 1800-1205 дугаартай утсыг аравдугаар сарын 2-ны өдрөөс эхлэн ажиллуулж байна...

### Хуульч, туршлагатай сайд

МАН мэргэжлийн Засгийн газар байгуулна гэж сонгуулийн өмнө амласан. Гэвч ялсныхаа дараа хэлсэн ярьсан, амласнаа мартаад мэргэжлийн бус Засгийн газар байгуулчихсан. Энэ засгийн газар 10 гаруй яамтай, тэр тооны сайдтай. Тэгвэл 10 гаруй сайдын дундаас салбартаа гологдохооргүй хэмжээний чадвартай, туршлагатай нь С.Бямбацогт. Ерөөс Хууль зүйн сайдаар УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, гишүүн асан Х.Тэмүүжин, АН-ын томоохон лидерүүдийн нэг Д.Дорлигжав гээд шилдэг улстөрчид ажиллаж байсан. Үнэхээр хууль гэдгийн мөн чанарыг мэддэг, чадварлаг улстөрчид энэ салбарт ажиллаж байсан учраас тэдний халааг авч, тамгийг гардах хүн нь жулдахааргүй байх ёстой байлаа. Харин МАН энэ салбарт С.Бямбацогт гишүүнийг томилсон нь нүдээ олсон хэрэг байсан. Тэрбээр 1998 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг Эдийн засагч мэргэжлээр төгсөж, 2005 онд Голландын Мастрихтын Их сургуулийг Бизнесийн удирдлагын магистер зэрэг хамгаалсан. Чамлахааргүй өндөр боловсролтой нэгэн. Мөн хуульч мэргэжлээр ч суралцаж, төгссөн. Дээрээс нь 2008, 2012, 2016 онд гурав дараалж УИХ-д сонгогдсон, туршлагатай гишүүн юм. Энэ хугацаанд С.Бямбацогт гишүүн МАН-ын лидер болж, олон хариуцлагатай албыг хашиж явсан. Ямар ч байсан түүнийг Хууль зүйн сайд боллоо гэхэд голсон хүн цөөхөн байсан болов уу.

### Хамгийн сайн ажиллаж байгаа сайд

Хууль зүй, Дотоод хэргийн яам гэдэг утгаараа хууль боловсруулах чиглэлд бусад яамдаас илүү ажиллах ёстой байх. Тиймдээ ч Хууль зүйн яам шинэ сайдтай болсноос хойш өнөөдрийг хүртэл чухал шаардлагатай хуулийн төслийг цөөнгүй хэдийг боловсруулж, УИХ, байнгын хороогоор хэлэлцүүлж байна. Тухайлбал, Төрийн албан хаагчийг оффшор бүсэд банкны данс эзэмших, мөнгөн хөрөнгө байршуулахыг хориглох чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьсан. Одоогоор байнгын хороогоор анхны хэлэлцүүлгээ хийгээд байна. Яахав, эхний удаад хэлэлцээд нэмэх шаардлагатай зүйлс байгаа учраас буцаачихсан байгаа. Улам сайжруулаад оруулж ирэх байх. Хуулийн төсөлд хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг бүх албан тушаалтан гадаад улсын нутаг дэвсгэрт өөрийн нэр дээр банкинд данс эзэмших, мөнгөн хөрөнгө байршуулах, хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглосон. Манай улсад нэн чухал шаардлагатай байгаа хууль. Гагцхүү бусад гишүүдийн хэлээд байгаа алдаа мадгыг засаад баталчих л хэрэгтэй байн. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд явж байна. Хууль батлагдсанаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан эрх зүйн орчин бүрдэх юм. Хэдийгээр өмнө нь батлагдсан багц хуулийг буцааж татсан асуудлын бай болсон ч Хууль зүйн яам энэ хуулийг илүү сайжруулж, тодорхойгүй бүдэг байсан заалтуудыг тодруулж оруулж ирж байгаа. Одоогоор хамгийн их анхаарал татсан, хүлээлт үүсгэсэн хуулийн төсөл болчихоод байна. Түүнээс гадна Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулав. Хуулийн төсөлд цагдаагийн албаны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, цагдаагийн албан хаагчийг үр бүтээлтэй тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, зөвхөн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зайлшгүй тохиолдолд хуулиар зөвшөөрөгдсөнхэмжээндхүний эрх, эрх чөлөөнд халддаг байх эрх зүйн орчныг бий болгох өөрчлөлтийг тусгаад байна. Гэх мэтээр 5-6 чухал шаардлагатай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, хэлэлцүүлж байгаа. Энэ бол салбарын сайд сайн ажиллаж байгаагийн жишээ. Ерөөс өнгөрсөн хугацаанд 10 гаруй сайдын хэн нь салбартаа илүү сайн ажиллаж байна вэ гэвэл С.Бямбацогт тэргүүтэй цөөхөн хэдэн хүнийг л нэрлэж болох байх.

### 100 хоногт хамгийн үр бүтээлтэй ажилласан

Засгийн газар 100 хоногийн ажлаа дүгнэж, салбар яамдууд ч хийсэн бүхнээ тайлагнасан. Ихэнх яамдын тайланд удахгүй шийдэх гэж, шийдвэрлэхээр зорьж байгаа гэсэн ажлын жагсаалт багтаж байлаа. Харин Хууль зүйн яамных арай дөнгүүр. Хамгийн чухал ажлуудаас нь дурьдахад л мэдэгдэнэ. Тухайлбал, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогтоор ахлуулсан ажлын хэсэг хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан зэргээр эрх ашгийг нь хохироосон асуудлыг судалж, санал дүгнэлт гаргасан. Энэ ажлын хүрээнд БНХАУ, БНСУ, ОХУ, Канад улсын ЭСЯ, МҮХАҮТ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын бизнесийн зөвлөлийн төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг нь хүлээн авч цаашид холбогдох арга хэмжээ авч ажиллахаар болсон юм. Мөн хилийн хориг тавигдсан дотоод, гадаадын 6000 орчим иргэний асуудлыг судалж үзээд холбогдох эрх бүхий байгууллагаас Монгол Улсын 298 иргэн, гадаадын 21 нийтдээ 319 иргэнд хориг тавьсан асуудлыг цуцалсан. Түүнээс гадна хуулиас давсан 100 гаруй дүрэм журам, тушаал шийдвэрийг цуцалсан. Дээрээс нь Архивын Ерөнхий газар иргэдэд архивын лавлагаа, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх 1800-1205 дугаартай утсыг аравдугаар сарын 2-ны өдрөөс эхлэн ажиллуулж байна. Иргэд бүх үүрэн телефоны дугаараас энгийн утасны тарифаар буюу нэг минутын 50 төгрөгөөр тус лавлах утсанд холбогдож, сонирхсон асуултдаа хариулт, лавлагаа үйлчилгээний талаар тодорхой мэдээлэл авах боломж бүрдлээ. "Тусгай дуут болон гэрлэн дохио" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, холбогдох журам зөрчин замын хөдөлгөөнд оролцсон 183 зөрчлийг илрүүлж, 45 тусгай дуут болон гэрлэн дохио хураан, 78 жолоочийг нийт 4.272.000 төгрөгөөр торгож, зөрчлийг цаашид дахин гаргахгүй байхыг анхааруулан 11 мэдэгдэл, шаардлага хүргүүлсэн. Гэх мэтээр тоочвол 100 хоногт нэгэнт хийгээд, хэрэгжүүлчихсэн ач холбогдолтой ажлууд олныг нэрлэж болно. Энэ утгаараа ХЗДХ-ийн яам, сайд С.Бямбацогт хамгийн үр бүтээлтэй ажлуудыг хийж, хэрэгжүүлжээ.

### Бизнес эрхэлдэг хүн бизнес эрхлэгчдийн зовлонг ойлгоно

Тэрбээр 1998-2000 онд "Ховдынөргөө"компанийн Ерөнхий менежерээр ажиллаж байгаад2000-2006онхүртэл"Нью прогресс" ХХК-ийн гүйцэтгэх захирал, улмаар энэ группийн ТУЗ-ийн даргаар ажилласан. Энэ мэтээр цөөнгүй жил компани удирдаж, ажилласан хүний хувьд бизнесмэнүүдээ яс махаараа мэдэрч, ойлгодог байх. Тиймдээ ч Ерөнхий сайдын захирамжаар хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдийн эрх ашгийг зөрчсөн асуудлыг судалж санал, дүгнэлт өгөх ажлын хэсэг байгуулахад Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогт ахалсан болов уу гэж санагдаад байгаа юм. Улмаар бизнес эрхлэгч, хувийн хэвшлийнхэн, мэргэжлийн холбоод, хөрөнгө оруулагчдын төлөөлөлтэй Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогт уулзаж, санал солилцсон. Уг уулзалтад Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын арьс шир үйлдвэрлэгчдийн холбоо, Уул уурхайн үндэсний ассоциаци, Хятадын хөрөнгө оруулагчдын холбоо болон зарим компанийн удирдлагууд оролцсон юм. Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогт уулзалтын үеэр "Төр байгаа бол хууль байх нь зүйн хэрэг. Хуулийг хүн бүхэн дагаж мөрдөх учиртай. Хуулийн хэрэгжилтийг хангуулахын төлөө төрийн захиргааны байгууллагууд ажилладаг. Ингэж ажиллахдаа ард түмэнд хүнд суртал үзүүлэхгүй, дарамт чирэгдэл үүсгэхгүй байх ёстой. Хэрвээ иргэдэд хүнд суртал гаргасан, дарамт учруулсан бол үүнийг судалж санал дүгнэлт гаргахаар ажлын хэсэг байгуулагдсан. Нэг хууль нөгөөтэйгээ зөрчилддөг хууль, эрхзүйн зөрчлийн тухай цөөнгүй ярилаа. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртхуульэрхзүйнорчныг боловсронгуй болгох чиглэлд анхаарч ажиллахаар тусгасан. Өөрөөр хэлбэл, бизнесийн эрх зүйн чиглэлд тодорхой асуудлыг шийднэ. Нэг хувийн татвар, жишиг татварын хуулийг батална гэж төлөвлөж байгаа. Нийтэд нь татвар нэмэх асуудал яриагүй гэдгийг ойлгох ёстой. Дотроо ялгаатай зохицуулалт байгаа юм. Тансаг хэрэглээнд татвар нэмэх асуудал ярьж байгааг ялгаж, салгаж ойлгох учиртай" хэмээн хэлсэн байсан. Бизнес эрхлэгчид ч жаргал, зовлонгоо хуваалцаж, санаа бодлоо ч илэрхийлцгээсэн. Харин өөрөө бизнес хийж байсан, УИХ-ын гишүүнээр гурван удаа сонгогдсон, хууль журам сайн мэддэг, салбарын сайдаар ажиллаж байгаа хүний хувьд тусгаж аваад, хэрэгжүүлэх, өөрчлөх, шийдэх байх гэж найдаж байна. Бизнес эрхлэгчдийн зовлонг бизнес эрхэлж байсан хүн л ойлгох учиртай.

## ЧУХАЛ ХҮН

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

*“Төв аймаг бол өөрийн гэсэн том хэрэгцээтэй, том хэрэглээтэй бүс нутаг. Тиймээс тэрхүү хэрэглээг орон нутгийн үйлдвэрлэгчдийн чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах явдал юм. Ингэж чадах аваас гадагшаа урсах их мөнгөний урсгал зогсоно. Үүний үр дүнд хуримтлагдсан тэр их мөнгө нь эргээд жижиг дунд бизнес эрхлэгчид , орон нутагт эдийн засгийн тэлэлт, хөгжилтийг авч ирэх ёстой юм” хэмээн холыг харж, хоёрыг бодож яваа эрхэм бол Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал. Нөгөөтэйгүүр, энэ эрхэмтэй ярилцаж суухад ажлаа мэддэг, ажил нь гарт нь орсон хүний зангараг шууд л мэдрэгдсэн. Их хоттой хаяа дэрлэн орших 83 мянган хүн амтай аймгийг зарим нь хөгжил муутай хэмээн шүүмжлэх нь бий. Гэвч та бид тэдний тогоо фуу өнгийн, жаргал зовлон нь юундаа байдгийг мэдэрсэн, хуваалцсан нь цөөн байж мэднэ. Харин өнөөдрийн тухайд Зуунмод хот хөгжиж дэвжих гарцаа тодорхойлсон төдийгүй шинэ өнгө төрхтэйгөөр ажиллаж амьдарцгааж байна билээ.*



# Ж.Батжаргал: АЙМГИЙНХАА ХЭРЭГЛЭЭГ ӨӨРСДИЙ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР ХАНГАХ БОД

**-Цаг үеийн байдалтай холбогдуулаад хоёулаа ярилцлагаа өвөлжилттэй холбоотой асуудлаар эхэлье. Сумдад өвөлжилт хэр байна?**

-Бид саяхан Засаг даргын зөвлөлийн ээлжит хуралдаанаар өвөлжилтийн бэлтгэлийн гүйцэтгэл, үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэж ярилцсан. Төв суурин болон хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл 90 гаруй хувьтай байна гэсэн нэгдсэн дүн мэдээ гарсан. Төв аймаг бол газар тариалангийн бүс учраас малын тэжээлийн асуудал дээр боломжийн хангагдсан гэж үзэж болно. Бид аюулгүй нөөц бүрдүүлэхтухайдшаардлагатай арга хэмжээнүүдийг аваад эхэлчихсэн. Энэ жилийн тухайд байгалийн хадлан бэлдэх асуудал нэлээд хүндэвтэр байсан. Аймгийн нийт нутгаар зуншлага, намаржилт боломжийн юм шиг хэрнээ хадлангийн гарц тааруутай байлаа. Тиймээс зэргэлдээх аймгуудын хадлангийн гарц сайтай сумдын нутгаас хадлангаа бэлтгэсэн. Сумдын аюулгүй нөөц бүрдүүлэлтэд аймгийн онцгой комиссоос анхаарал хандуулж, тал хээрийн есөн сумдад сая тонн өвс бэлтгэх шаардлагатай хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас шийдвэрлэж өглөө. Энэ мэтчилэн өвөлжилт хүндэрч болзошгүй үед авах яаралтай арга хэмжээтэй асуудлуудыг шийдвэрлэсэн. Өвөлжилтийн бэлтгэл чухамдаа малчны хотоос эхлэх ёстойг малчиддаа маш сайн ойлгуулсан нь өвөлжилтийг давж гарах нөхцөл болно шүү дээ. Малчин өрхүүд маань хадлан тэжээлээ өөрсдийн хэр чадлаар бэлтгэж авлаа гэж дүгнэгдэж байна. Төлөвлөгөө ёсоор аймгийн аюулгүй нөөцөд 605 мянган тонн хадлан бэлтгэх ёстой. Төлөвлөгөө биелсэн. Одоогийн байдлаар аймаг дундын отрын нөөц нутагт руу 300 гаруй мянган толгой мал орж өвөлжинө. Баруун хойд бүс нутагт өвөлжих малчин өрхүүд нүүгээд очичхсон. Зүүн талд байгаа отрын нөөц нутаг буюу Хэрлэн- Баян-Улааны отрын нөөц нутагт өвөлжих малчид хүлээлтийн байдалд өвөлжиж байгаа. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулаад отрын нөөц нутаг руу орох малын тоо, хөдөлгөөнийг хязгаарлачихаад байгаа юм. Гэхдээ холбогдох яамандаа хүсэлт тавьсан. Халдварын голомттой, хорио цээрийн дэглэм тогтоосон байгаа тэр бүсээс нь өөр бүс рүү оторлох талаас нь шийдвэр гаргаж өгнө үү гэсэн хүсэлтийг тавьсан. Удахгүй хариу нь ирэх байх.

> ...Энэ жилийн тушаагдсан буудайн өртөг мөнгөний асуудал бүрэн шийдэгдээгүй асуудал бий. Гэхдээ авсан уу авсан. Тушаасан уу тушаасан. Тиймээс тодорхой хугацаанд шийдэгдэнэ гэж үзэж байгаа. Харин төмс тарьсан аж ахуй нэгж, иргэдийн хувьд хүндхэн жил болчихлоо. Төмсний боловсруулалтын үеэр буюу өнгөрсөн долдугаар сарын сүүлч, наймдугаар сарын эхээр их халсны улмаас нийт хурааж авсан ургацын 60 орчим хувь нь үрийн төмс гарсан...

**-Идэр есийн жавар тачигнахтай зэрэгцээд аймаг, сумдууд уурын зуух нүүрсгүй боллоо, дулааны шугам хоолойнууд хөлдлөө гэцгээдэг нэг зовлон байдаг?**

-Манай аймаг өнөөдрийн байдлаар 7-14 хоногийн нүүрсний нөөцтэй. Нийт сумдын 14 нь нэгдсэн халаалтын системд шилжчихсэн. Халаалтынх нь үйл ажиллагааг тодорхой аж ахуйн байгууллага хариуцаад явдаг. Аж ахуй нэгжүүд нь ч хөрөнгө санхүүгийн хувьд чадамжтай, техник, технологийн шинэчлэл гайгүй хийчихсэн, нүүрс түлээнийхээ асуудлыг цаг хугацаанд нь бүрэн татаад халаалтан дээрээ ямар нэгэн доголдол гаргахгүй ажиллаад яваад хэвшчихэж. Аймгийн төвийн халаалтыг орон нутгийн өмчит аж ахуй шийдэж явдаг. Ерөнхийдөө тогоо, шугамны ажиллагаа, тохируулга хэвийн. Харин бидэнд нэн даруй шийдэх ёстой зүйл юу байсан гэвэл халаалт, дулаантай холбоотой 700-аад сая төгрөгийн өр. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам маань өөрийнхөө салбарын өрийн асуудлыг сая төсвийн тодотголоороо шийдсэн. Эрүүл мэндийн салбар маань мөн шийдсэн. Тиймээс халаалтын салбар дээр өр авлаганаас болж хүндрэх зүйл гарахгүй байх. Төсвийн эрх захирагч нарт нэмж өр, авлага үүсгэхгүй ажиллах, байгууллагуудын хэвийн ажиллагааг хангах асуудал дээр хийгдсэн гэрээ хэлэлцлээ нарийн тооцож ажилла гэдэг чиглэл өгсөн.

**-Монгол Улс гурилтай, талхтай байх асуудлыг Сэлэнгэ, Төв, Булган гэсэн гуравхан том аймаг ерөнхийдөө шийддэг. Төмс, хүнсний ногооны тухайд ч адил. Өнөөдрийн байдлаар үтрэм дээр борлогдоогүй, эдийн засгийн эргэлтэд ороогүй байгаа улаан буудай байна уу. Энэ намар тариаланчид, ногоочид маань өрөө барагдуулж чадсан болов уу?**

-Энэ жил газар тариалангийн салбарын үр өгөөж дундаж төвшинд байна гэж харж байгаа. Манай аймаг 80 гаруй мянган тонн үр тариа хурааж авлаа. Нэгжийн ургац 11.4 центр. Төмс 54 мянган тонн. Нэгжийн ургац 90 орчим центр. Хүнсний ногоо 7000 орчим тонн. Малын тэжээлийн ургамал 11 орчим мянган тонн. Борлогдоогүй үлдсэн 12 орчим мянган тонн улаан буудайг гурилын үйлдвэрүүдэд өгөх арга хэмжээг зохион байгуулаад явж байна. Энэ жилийн тушаагдсан буудайн өртөг мөнгөний асуудал бүрэн шийдэгдээгүй асуудал бий. Гэхдээ авсан уу авсан. Тушаасан уу тушаасан. Тиймээс тодорхой хугацаанд шийдэгдэнэ гэж үзэж байгаа. Харин төмс тарьсан аж ахуй нэгж, иргэдийн хувьд хүндхэн жил болчихлоо. Төмсний боловсруулалтын үеэр буюу өнгөрсөн долдугаар сарын



## ЧУХАЛ ХҮН

сүүлч, наймдугаар сарын эхээр их халсны улмаас нийт хурааж авсан ургацын 60 орчим хувь нь үрийн төмс гарсан. Энэ нь санхүүгийн хувьд нэлээд алдагдалтай хүнд жил болж өнгөрлөө гэсэн үг. Төв аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой болгох үүднээс "Газар тариалангийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн гарц" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, Дарханы ургамал газар тариалангийн хүрээлэн холбогдох яам, тамгын газрын мэргэжилтнүүдийг урьж оролцуулан газар тариалангийн салбарын өнөөгийн байдалд бодитой үнэлэлт, дүгнэлт өгье цаашид баримтлах бодлогоо боловсронгуй болгоё хэмээж буй. Дээр нь энэ газар тариалангийн бодлогыг дагалдуулж хэд хэдэн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Тухайлбал, нэгдүгээрт, хөрсний үржил шимийг сайжруулах, хөрс хамгааллын асуудал байна. Техник, технологийн шинэчлэлт, боловсон хүчний мэргэжлийн удирдлагыг хангах, үр бордооны асуудлыг тус тус авч үзэх шаардлага байгаа юм. Монгол Улсад шинжлэх ухааны байгууллагуудаар тодорхой судалгаа тооцооллоороо үр хураасан талбай руу мал орж нөгөө хамгаалагдсан хөрсийг нь үймүүлээд байгаа байхгүй юу. Орон нутаг аль болох зохицуулахыг хичээж буй. Аймаг газар тариалангийнхаа үйлдвэрлэлийг дагаж эрчимжсэн мал аж ахуйгаа хөгжүүлэх ёстой гэсэн бодлого баримталж байгаа. Энэ бол хоёр талаасаа нэлээн сайн ярилцаж, зөвшилцөж, цаг хугацааны хувьд тохиролцож байж шийдэх ёстой асуудал. Ер нь бол харилцан тэтгэж, хослох хэлбэрээр хөгжих ёстой ийм л салбар гэж би хувьдаа ойлгодог.

**-Төв халх руу "довтолсон" их нүүдэл ерөнхийдөө зогсч байх шиг байна. Гэвч өвөлжөө буудаа булаацалдсан маргаан орон нутагт тасрахгүй байна гэх мэдээллийг уншиж байсан?**

-Ер нь бол нүүдэл мэр сэр бий. Идэвхитэй үеэ бодвол арай саарч буй. Байгаль дэлхий өөрийн гэсэн чадамжтай. Тэр чадамжид л зохицож амьдрах ёстой. Уугуул иргэд байна уу, суугуул нь байна уу хамаагүй. Төв аймгийн нутаг дэвсгэр хэчнээн мянган толгой мал бэлчээх, бэлчээрийн даац чадамжтай байна түүнд зохицуулах ёстой. Тэгэхээр төр, орон нутаг байгалийнхаа даац чадамждаа зохицуулсан байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, энэ том зах зээлийг манай аймгийн иргэд эзлэх учиртай, хангах үүрэгтэй. Энэ нь өөрөө Төв аймгийн эрх ашиг. Жишээ нь, Төв аймгийн жижиг дунд бизнес эрхлэгч, гар урлал эрхэлдэг иргэдийн лангуу тэр татваргүй барааны дэлгүүрт нь байх шаардлагатай. Энэ мэтчилэнгээр манай аймгийн иргэн бүрийн амьдралд Хөшигийн хөндий дэх нисэх

...Төв аймаг гурван махны үйлдвэртэй. Баяндэлгэр, Эрдэнэ, Зуунмодод бий. Гурван махны үйлдвэртэй хэдий ч хүчин чадал нь өндөр биш. Тиймээс суурьлагдсан хүчин чадлыг нь бүрэн хэмжээнд ашиглах тухайд онцгой анхаарал хандуулж байна...

мянган сурагчийнхаа дүрэмт хувцас үйлдвэрлээд тарааж яагаад болохгүй гэж. Энэ бол зөв хоршилт. Эдийн засаг тэр хэмжээгээр сэргэнэ, өснө. Гэх мэтчилэн хоорондоо нь холбож чадвал зах зээлийн эрэлт, нийлүүлэлт дээр тулгуурлан харилцан зохицоод явбал урагшаа ахих боломж байна.

**-Үүдэнд саяхан махны үйлдвэр гэж яриа чих дэлсэх шиг болсон. Шинэ үйлдвэр ашиглалтад орж байгаа юм уу эсвэл?**

-Төв аймаг гурван махны үйлдвэртэй. Баяндэлгэр, Эрдэнэ, Зуунмодод бий. Гурван махны үйлдвэртэй хэдий ч хүчин чадал нь өндөр биш. Тиймээс суурьлагдсан хүчин чадлыг нь бүрэн хэмжээнд ашиглах тухайд онцгой анхаарал хандуулж байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт сум болгонд цомхон технологи бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан мал нядалгааны газрууд байгуулах. Тэнд махлагдсан махыг махны үйлдвэрээр дамжуулан гадаад зах зээл рүү гаргах ийм асуудлыг ажил хэрэг болгоно. Ингэж чадах юм бол мал аж ахуйн салбарын гол нэрийн бүтээгдэхүүн болсон махыг эдийн засгийн эргэлтэд оруулж чадна. Ер нь төр малчдад зээл олгох бодлого барихаас зарлага гаргана. Үүнээс орон нутгийн суурь зардалд 19 орчим тэрбум төгрөгний зарлага гаргаж, улсаас 7.8 тэрбум төгрөгний санхүүгийн дэмжлэг авах, орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан 3.5 тэрбум төгрөгний дэмжлэг авахаар батлагдлаа. Түүнчлэн өмнөх оноос дамжиж ирсэн өрийн асуудлыг шийднэ. Шинэ бүрэн эрхийн хугацааныхаа зорилтод арга хэмжээ рүүгээ чиглүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад надад 700-гаад сая төгрөгний хөрөнгийн эх үүсвэр үлдэж байх шиг байна. Энэ мөрийн хөтөлбөр буюу 2017 онд хийх ажлын маань гол чиглэл бол ажилтай, орлоготой түшиглэсэн аялал жуулчлалын парк байгуулах тухай асуудал Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зорилтод байна. Ерөнхий төсөөлж байгаа байдлаар нь авч үзэх юм бол ихээхэн хөрөнгө хүч шаардагдана. Зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулах, ажлыг эхлүүлэх зэрэг асуудлыг барьж ашиглах концессын гэрээгээр гүйцэтгэвэл дээр байх. Эдийн засаг хүнд, төсөв санхүү хүндрэлтэй байгаа үед орон нутаг өөрийнхөө хөрөнгөөр бүтээнэ гэвэл бүтэхгүй. Тиймээс зөв арга хэлбэрээр, зах зээлийнх нь жаягаар асуудлыг шийдэх гарц гаргалгааг хайх ёстой. Хийдийнх нь орчныг



# Н ЧАНАРТАЙ ДЛОГО БАРЬЖ АЖИЛЛАНА

ашигтай байна гээд тогтоодсон үр сортуудыг үйлдвэрлэлд ашиглах, нутагшуулах тал дээр нь онцгой анхаарч ажиллах шаардлага байгаа. Уранш боловсруулах, сэлгээг зөв шийдэх ёстой юм байна. Ингэж байж тогтвортой ургац авдаг бололцоо бүрдэнэ. Хоёрдугаарт, Төв аймаг газар зүйн байрлалынхаа хувьд Сэлэнгэтэй харьцуулах юм бол арай өвөрмөц. Хойд талын газар тариалангийн бүсийн сумдууд маань Сэлэнгэ аймагтай хөрсний үржил шимийн хувьд төстэй. Гэтэл урд тал нь тааруу. Тиймээс газар тариалангийн үйлдвэрлэл дотроо аль бүс нутагт ямар сортын ургамал тариалах ёстой юм бэ гэх тухайд тодорхой болгож авна. Төв аймагт эрчимжсэн аж ахуй нэлээд хөгжиж буй. Эдний тэжээлийн хэрэгцээ маш их. Тиймээс малын тэжээлийн үйлдвэрлэлийн асуудлыг нэлээд онцгой анхаарах ёстой. Тодорхой бүс нутгуудад малын тэжээлийн ургамлын тариалалт, үйлдвэрлэлийн асуудлыг шийдэж чадах аваас газар тариалангийн салбарын хөгжил цаашлаад уг салбарыг түшиглэн ажиллаж байгаа иргэдийн амьдрал дээшлэх бололцоотой. Хүнсний ногооны үйлдвэрлэлийг хоёр дахин нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Өөрийнхөө аймгийн нутаг дэвсгэрт сая гаруй хүн амтай нийслэл хот гэж айлыг багтаачихаад энэ айлын их хүнсний хэрэгцээг, эх орныхоо хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хэрэгцээг хангах, зах зээлийг нь эзлэх тухайдбидсанал,санаачлагатай ажиллах ёстой. Тэр утгаараа төмс, хүнсний ногооныхоо тариалалтад онцгой анхаарал хандуулаад зогсохгүй борлуулалтын сүлжээг нь шийдэе хамгаалагдсан хөрсний тариалалтыг ч нэмэгдүүлэх шаардлага байна гэж үзэж байна.

**-Газар тариалангийн бүс нутагт малчин, тариаланч хоёрын бэлчээр нутгийн асуудлыг шийдвэрлэх цаг болсон. Энэ талын гомдол, санал танд ирэв үү?**

-Мэдээж ирсэн. Чухамдаа энэ хоёр үйлдвэрлэл хоорондоо хоршиж байж үр дүн нь гарах ёстой юм. Амьдрал дээр хоорондоо зөрчилдөж байгаа зүйлүүд бий. Ургац хурааж дуусаад бодлого баримтлах ёстой. Энэ үүднээс бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг нь сум, багууд боловсруулж, багийн иргэдийн нийтийн хурлаар нь хэлэлцүүлж батлуулна. Түүн дээрээ тулгуурлаж бэлчээрийн хамгаалалт, ашиглалтынх нь цогц үйл ажиллагаа явагдах юм. Мал хэчнээн өсөөд ч бэлчээр байхгүй бол тэр баялаг биш. Тэгэхээр бид яах ёстой вэ гэхээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх явдал. Мянган малаас авдаг ашиг шимийг бид 500-600 малаас л авдаг байх ёстой. Гэхдээ уламжлалт мал аж ахуйгаа устгаж болохгүй. Нутгийн шилмэл малаар нь сайжруулж, энэ аж ахуйгаа өнө мөнхөд авч явах ёстой. Ингэхдээ хаяа багтвал бууж, хамар багтвал иддэг гэдэг зарчимаар биш, байгаль дэлхийн хувьсан өөрчлөлттэй уялдуулж, байгалийнхаа даац чадамжид зохицсон малтайгаа, амьдрал ахуйгаа авч явах ийм л шинжлэх ухааны үндэстэй, зөв ойлголт, төлөвлөлттэйгөөр хөгжүүлэх шаардлагатай байна. Дээр нь бэлчээр усжуулалтад анхаарах цаг болжээ. Хоёрдугаарт, бэлчээрийн мэрэгчид шавьжтай тэмцэх асуудлыг онцгойлон анхаармаар байна. Эцэст хэлэхэд, Засаг даргын мөрийн хөтөлбөрт хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа мал аж ахуйн салбарын талаар баримтлах бодлого төсөөллүүдэд дээр өгүүлсэн чиг хандлага нэлээн суусан.

**- Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ирэх онд ашиглалтад орно. Үүнийг та бүгд эдийн засаг эрс сайжрах нөхцөл бүрдэж байна гэж харж байгаа байх. Засаг дарга та ч гэсэн цээжнийхээ мухарт маш нарийн тооцоог хийсэн нь дамжиггүй?**

-Орон нутгийн эрх ашигт нийцсэн бодлого хэрэгжүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн яам, ИНЕГ гээд холбогдох байгууллагуудад хүсэлтээ тавьсан. Хөшигийн нисэх онгоцны буудлыг дагаж томоохон суурин бий болоод зогсохгүй агуулах зоорийн гэдэг юм уу терминал, тээвэр ложистик гэж ярьдаг үйлчилгээний салбарууд гарч ирэх ёстой. Энэ салбаруудад Төв аймгийн аж ахуйн нэгж байгууллагууддавууэрхтэйгээр бүтээгдэхүүнээ нийлүүлдэг буудал ямар нэг байдлаар сайнаар нөлөөлөх ёстой гэж бид үзэж байгаа. Хамгийн гол нь Төв аймгийн үйлдвэрлэгчид бусдаас давуу эрх эдлэх ёстой. Аймгийн удирдлагууд ч энэ асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Тодорхой санамж, хэлэлцлүүдийг ч хийнэ.

**-Төв аймаг эдийн засгийн хувьд хэр чадамжтай вэ?**

-Бидэнд санхүүгийн хувьд бие даах боломж уг нь бий. Төв аймгийн газар зүйн байршилд давуу тал ч бий, сөрөг зүйл бий. Төв аймгийг хөгжил муутай гэцгээдэг. Олон жил ярьж байна даа. Үнэнийг хэлэхэд,их хоттой хаяа залгах сумдын хөгжилд том хот сайнаар нөлөөлөх нь ч бий, сөргөөр нөлөөлөх нь ч бий. Жишээ дурдая. Бусад аймгийн төвүүд шиг сүлжээ том дэлгүүр оруулж ирэх шаардлага бидэнд алга. Хэд хэдийг байгуулж үзсэн. Ойрхон сумдын иргэд долоо хоногт хоёр удаа Улаанбаатар орж байна. Сайн тал гэвэл манай иргэд хотын үнээр бараа бүтээгдэхүүнээ худалдаж авдаг. Бизнес эрхлэгчдэд тээврийн зардал шингээх шаардлага байхгүй. Харамсалтай нь энэ нь иргэндээ аятай боловч аймгийн эдийн засгийн хөгжилд таатай зүйл биш. Бидний баримталж байгаа бодлого гэвэл манайх бол өөрийн гэсэн том хэрэгцээтэй, хэрэглээтэй аймаг. Тиймээс энэ хэрэглээг бид өөрсдийн чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах явдал юм. Ингэж чадах аваас Улаанбаатар руу руу урсах их мөнгөний урсгалыг зогсооно. Тэгж хурааж чадсан мөнгөөрөө үйлдвэрлэлээ хөгжүүлж, эдийн засгаа сэргээж, тэлэлт бий болгоно. Өнөөдөр аймгийн хэмжээнд 15 мянга орчим хүүхэд сургуульд, 7000 орчим хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байна. Энэ хүүхдүүдийн хүнсний болон зөөлөн эдийн хэрэгцээг бид өөрсдөө хангах ёстой. Түүнээс Улаанбаатараас, төвлөрсөн зах, сүлжээ дэлгүүрээс хангамааргүй байна. Бидэнд боломж бий. Баянцогт суманд жилд 2000 тонн ноос угаах хүчин чадал бүхий үйлдвэр бий. Гэтэл манай аймаг хоёр сая хоньтой. Хонины самнасан ноосоо тэндээ тушааж, утас ээрүүлэн даавуу болгоод түүгээр 15 илүүтэйгээр мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ ханшыг тогтвортой, борлуулалт сайтай байлгах бодлого чухал . Малчид зээл авч байх ямар шаардлага байгаа юм. Малын ашиг шим, түүхий эдээ зах зээлд ямар ч төвөггүй борлуулах, борлуулсан бүтээгдэхүүн нь амьдрал ахуйгаа аваад явах хэмжээний орлогоо олж чадаж байвал болж байна. Дээр нь бүтээгдэхүүнээ боловсруулах нэмүү өртөг шингээх тал руу нь онцгой анхаарах ётсой. Тийм бааз суурийг бий болгож өгөх ёстой. Эдийн засаг сайнгүй, төсөв санхүү хүнд байгаа энэ үед Төв аймгийн барьж байгаа нэг бодлого бол төсөл хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллахыг гол зорилгоо болгон ажллаж байна. Бүх салбар дээр төслийн нэгжүүд байгуулах ёстой гэж үзэж байгаа. Материаллаг буюу баялаг бүтээгч салбарт ч тэр. Нийгэм, соёлын салбарт ч ялгаагүй. Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүд хувийн хөрөнгө оруулалтыг татах, төр хувийн хэшлийн түншлэл дээр асуудлыг шийдэх, өмнө нь бий болгосон төвшингөө унагахгүй тэрнээсээ ахисан өсөлт, орлого, хөгжил бий болгосон байдлаар давахын тулд бидэнд нэмэгдэл эх үүсвэр, идэвхи зүтгэл шаардлага зайлшгүй байна. Үүний нэг нь төсөл хөтөлбөрийг орон нутагтаа шингээх асуудал юм аа.

**-2016 оныг сонгуульдсаар дуусгалаа. Одоо бүх хүний итгэл найдвар 2017 оны төсөв. Төв аймгийн 2017 оны төсвийн өнгө аяс ямар байна?**

-УИХ-аас Монгол Улсын төсвийг баталсан. Орон нутгуудад хуваарилагдах хөрөнгө тодорхой болсон. Төв аймаг 2017 онд 12 орчим тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, нийт дүнгээрээ 65 орчим тэрбум төгрөгийн

иргэний тухай асуудал. Би үүний төлөө л ажиллаж байна. Тиймээс ажлын байр нэмэгдүүлэх, баялаг бүтээж байгаа, юм хийе бүтээе гэж байгаа иргэдээ дэмжих болно. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, аймаг, сум хөгжүүлэх сан гээд тусгай сангуудын хөрөнгийн эх үүсвэрүүдийг хийж бүтээе гээд зүтгэж байгаа эрэлхийлж байгаа, хийж бүтээсэн нь танигдсан үндсэндээ 4-5 жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн иргэдээ дэмжихэд зориулна. Бодлого, хөрөнгө санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлж ажиллах ёстой. Ингэж байж ядуурал, ажилгүйдлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлнэ. Мэдээж төв суурин газруудын тохижилт, дэд бүтэц сайжруулалт, орон сууцны нөхцлийг сайжруулах, засвар үйлчилгээ гээд олон зүйлд анхаарал хандуулна. Энэ бүхэнд 700-гаад сая төгрөг хаана ч үгүй л дээ. Тиймээс төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийнхнийг татах, тэднийг дэмжих, хамтын ажиллагааг сайжруулах ёстой.

**-Бид зам зуураа ярилцаж л байлаа. Манзушир гэж сайхан хийд бий. Дэлхийд ганцхан Манзушир хийдээ эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр та юу хийх вэ?**

-Манзуширын хийдийг

үндэсний итгэл үнэмшил, соёл, зан заншлыг эвдэхгүй тийм хөрөнгө оруулалтыг татах хэрэгтэй байгаа юм. Нөгөөтэйгүүр, Манзуширын ам маань өөрөө Төв аймгийн нутаг дэвсгэрт хамаагүй. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт хамаарагддаг. Дээр нь байгаль орчны яам, Богд уулын Дархан газрын захиргаа хамгаалалтын горим менежментийг нь барьдаг. Нэлээн хэдэн байгууллагын хамтын ажиллагаа, зөв харилцаа, шийдэл дээр тулгуурлаж байж асуудал бодит ажил болох гээд байгаа зүйл ээ энэ чинь. Олон жил ярьж байгаа юм. Төв аймгийн хажууд залгаад байж байгаа Богд уулын энгэрийн газар нутгийн асуудал бол Төв аймгийн харьяалагдаж, Төв аймгаас энэ газрын бодлого үйл ажиллагаанд чиглэгдэж хамгаалалтын арга хэмжээ юмнууд явагдаж бас тодорхой дархан газрын хамгаалалтын бүст хэрэгжүүлж болдог аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бололцоо боломжийг бүрдүүлдэг гэх мэтчилэн энэ зүйлүүдийг шийдэх ёстой. Үндсэн хуульд байж байгаа газар нутгийн хилийн суурьшилтын асуудал хоёр талын нэгдэл дээр шийдэгддэг учраас бидний санасан зоргоор асуудал бас шийдэгдэж чадахгүй байна. Нэлээд олон жил болж байгаа зүйл.


## ЭЛСЭЛТИЙН ЗАР

"Зохиомж" дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

**Жич:**

-IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нөхүүлнэ

-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

**Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.**
**Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021**

# ДЭЛХИЙ



Орчуулсан Б.ДАВАА

*АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрөгч сарын 8-ний өдөр явагдаж, улс төрийн туршлагагүй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулан Нэгдсэн улсын 45 дахь Ерөнхийлөгчөөр тодорсон билээ. Сонгуулийн дүн албан ёсоор гарсны дараа тэрбээр гэр бүлийнхээ хамт CBS телевизийн нэвтрүүлэгт оролцож ярилцлага өгсөн байдаг. Тиймээс энэ удаагийн буландаа түүний ярилцлагаас орчуулан хүргэж байна.*

# Доналд Трамп: ЦАГААЧЛАЛЫН ХУУЛИЙГ ИЛҮҮ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД Л АНХААРНА

**-Юуны өмнө баяр хүргэе, Трамп. Та Ерөнхийлөгч болох нь?**

-Баярлалаа.

**-Сонгуулийн үр дүнг хараад гайхав уу?**

-Бидний хийж буй ажил үр дүнгээ өгнө гэдгийг мэдэж байсан учир гайхаагүй. 21 өдрийн турш тасралтгүй илтгэл тавьж байсны зэрэгцээ нэг өдөрт хэд хэдэн удаа ч ярих тохиолдол гарч байлаа. Харин сонгуулийн сурталчилгааны сүүлийн хоёр өдөр миний хувьд маш сайхан үе байсан. Зургаа, долоон ч удаа илтгэл тавьсан байх.

**-Гэхдээ хүн бүр л өөрийг тань сонгуульд ялагдана гэж бодож байсан?**

-Би хамгийн сүүлийн илтгэлээ Мичиганд өглөөний 01:00 цагт тавьсан юм л даа. 31 мянган хүн цугларсан байлаа. Талбайн гадна нь ч маш олон хүн байсан. Өмнөх өдрийн уулзалтын төгсгөлд би “Бид яагаад ялагдах ёстой юм бэ” гэж хэлсэн. Харин тэр өглөө 01:00 цагт би “Бид ялагдагч шиг харагдахгүй байна” гэсэн. Бид үнэхээр урам зоригтой байж билээ.

**-Сонгуулийн орой таныг чив чимээгүйхэн ялалтаа зарлахаар гарч явсан гэж сонссон юм байна. Таны хувьд асар олон зүйл биелсэн мөч байсан байх?**

-Үнэхээр гайхалтай мөч байлаа. Өмнө нь хэзээ ч хийж байгаагүй асар том зүйлийн ард гарч чадсан. Энэ бол маш том, бас гайхалтай.

**-Амьсгалж ч, ярьж ч чадахгүй байв уу?**

-Бага багаар амьсгалаад л. Миний амьдрал бүхэлдээ өөрчлөгдөж буй мэт санагдсан.

**-Хиллари Клинтон тань руу залгасан гэсэн. Тэрхүү дуудлагын талаар бидэнд яриач?**

-Тийм ээ, Хиллари над руу залгасан. Их сайхан яриа болж өнгөрсөн. Гэхдээ мэдээж, түүний хувьд хүндхэн л байсан байх. Хиллари ямар байдалтай байсныг би төсөөлж л байна. Магадгүй надаас ч илүү хүнд байсан болов уу. Үнэнийг хэлэхэд, надад ч бас хэцүү байлаа. Тэр над руу залгаад зүгээр л “Баяр хүргэе, Доналд. Чи чадлаа” гэж хэлсэн. Би хариуд нь “Маш их баярлалаа. Чи ч гэсэн үнэхээр хүчтэй өрсөлдөгч байлаа” гэж билээ. Хиллари маш хүчтэй, бас ухаалаг бүсгүй.

**-Харин Билл Клинтоны тухайд. Та түүнтэй ярьсан уу?**

-Билл маргааш нь ярьсан.

**-Тийм үү. Тэгээд юу гэж хэлсэн бэ?**

-Яг үнэндээ өчигдөр шөнө над руу ярьсан юм байна.

**-Тэгээд юуярив даа?**

-Тэр тийм ч эелдэг байгаагүй. Хүнд өрсөлдөөн байлаа гэсэн. Түүний харж байсан хамгийн хүндхэн өрсөлдөөн байсан гэж хэлсэн дээ.

> ...Бидний тооцоолж буйгаар гэмт хэрэгтэн, гэмт хэргийн бүлэглэл, хар тамхины наймаачид гэх мэт хоёр, эсвэл гурван сая хууль бус цагаачид байгаа. Тэднийг эх орноосоо хөөж, эсвэл шоронд хорино. Тэд бол хууль бус оршин суугчид. Тиймээс бид өөрсдийнх нь улс орон руу албадан гаргах хэрэгтэй...

**-Кампанитынхаа үеэр та нэлээд ёс журамгүй авирласан. Ер нь түүний талаар хэлсэн үгэндээ одоо харамсдаг уу?**

-Аль аль нь л өөдгүй загнасан байх. Тэд хүндхэн байдал орсон бол би ч бас адил нөхцөл байдалд байсан. Би харамсах ёстой гэж үү. Улсынхаа төлөө гэсэн чин сэтгэл надад байхгүй байсан бол одоо чамтай ингээд сууж байхгүй. Бид аугаа Америкийг дахин сэргээнэ. Энэ амлалтаа биелүүлэхийн тулд яг одооноос эхлэх хэрэгтэй. Хийх ажил их байна.

**-Тэгэхээр огт харамсдаггүй гэсэн үг байх нь ээ?**

-Би харамсахгүй байна. Би илүү зөөлөн, илүү эелдэг байхыг хүссэн бол магадгүй баахан бодлого ярьж, эсвэл таны сонсохыг хүсээд буй тэр үгийг хэлэх байсан байх. Гэхдээ яг үнэнийг хэлэхэд, өөрийн явуулсан сурталчилгаагаараа бахархаж байна.

**-Хууль бус цагаачдыг ямар байдлаар албадан гаргах вэ?**

-Бидний тооцоолж буйгаар гэмт хэрэгтэн, гэмт хэргийн бүлэглэл, хар тамхины наймаачид гэх мэт хоёр, эсвэл гурван сая хууль бус цагаач байгаа. Тэднийг эх орноосоо хөөж, эсвэл шоронд хорино. Тэд бол хууль бус оршин суугчид. Тиймээс бид өөрсдийнх нь улс орон руу албадан гаргах хэрэгтэй. Хилийн аюулгүй байдал хангагдаж, бүх зүйл зөв горимдоо орсон цагт л бид аз жаргалтай, гайхалтай ард түмний талаар ярьж суух байх. Гэхдээ юу юунаас ч илүү хилийн аюулгүй байдлыг бий болгохыг хүсч байна.

**-Одоо таны кабинетын тухай ярилцая?**

-За

**-Ер нь бол аль хэдийнэ шийдвэрээ гаргачихсан уу?**

-Тэгэлгүй яах вэ.

**-Бидэнд сонирхуулаач?**

-Шийдвэрээ гаргачихсан. Гэхдээ энд ярихгүй.

**-Сонгуулийн сурталчилгааныхаа үеэр та үр хөндөлтийг хуулиар зөвшөөрөхийг эсэргүүцдэг эрхмийг Дээд шүүхэд томилно гэж ярьж байсан. Магадгүй үр хөндөлтийг зөвшөөрөх тухай хуулийг хүчингүй болгох нэгнийг томилохоор хайж байгаа байх?**

-Би үр хөндөлтийн эсрэг байр суурьтай байх болно. Шүүгчид ч гэсэн үр хөндөлтийн эсрэг байх учиртай.

**-Та цалин авах уу?**

-Энэ талаар тайлбар хиймээргүй байна. Гэхдээ миний хариулт бол “Үгүй”. Хуулийн дагуу хамгийн бага цалин буюу нэг ам.долларын цалин авах бодолтой байгаа. Би жилд ердөө л нэг ам.долларын цалин авна. Гэхдээ энэ талаар сайн хэлж мэдэхгүй байна. Чи цалин хэд байдгийг мэдэх үү.

**-400 мянган ам.долларыг та авна?**

-Би цалин авахгүй. Үүнийг авахгүй.

**-Улс орны яг өнөөгийн нөхцөл байдлын талаар танаас хэдэн асуулт асуумаар байна. Үнэн хэрэгтээ маш олон хүмүүс айж байна. Африк гаралтай америкчууд өөрсдийг нь нутаг буцаана гэж бодож байгаа. Мусальман шашинтнууд ч гэсэн айдастай амьдарч байна?**

-Тэдний айх зүйл нь өөр. Миний бодлоор хэвлэл мэдээлэл л энэ бүгдийг бий болгож байгаа. Ний нуугүй хэлэхэд, энэ улс оронд болж буй маш жижиг хэргийг ч өмнө нь байгаагүй мэт том асуудал болгон дэвэргэх нь бий.

**-Айдастай байгаа хүмүүсийн нэгэн төлөөлөл бол бэлгийн цөөнх. Та энэ тал дээр юу хэлэх вэ?**

-Тэдний талаар БНН-ын Үндэсний хүний эрхийн конвенцид дурьдсан байгаа.

**-Таны хувьд?**

-Хүн бүр л ярьдаг. Би бол тэдний эрхийг дэмжигч.

**-Тэгвэл бэлгийн цөөнхийнхөн ч тэгш эрхтэйгээр гэрлэх болох нь ээ. Та тэдний гэрлэлтийг хуулиараа зөвшөөрөхийг дэмжих үү?**

-Миний зөвшөөрөх эсэх огт хамаагүй. Учир нь хуульд аль хэдийнэ тусгагдчихсан. Улсын дээд шүүхээр шийдвэрлэгдээд явж байгаа.

**-Та хэт даврагч Лалын улс бүлэглэлийг устгана гэж хэлсэн. Одоогоор юу хийхээр зэхэж байна вэ?**

-Би тэр талаар юу ч ярихгүй.

**-Яагаад тэр билээ?**

-Мосул хот руу довтлохоосоо бүр дөрвөн сарын өмнө яг одоо бид дайрах гэж байна хэмээн сүр дуулиан болгож зарладаг хүмүүстэй би огт адилгүй. Дайн гэдэг тийм амар зүйл биш.

**-Та хуурай замын цэрэг хөдөлгөх үү?**

-Би ямар нэг зүйл ярихыг хүсэхгүй байна.

**-Та Ерөнхийлөгчийн тангарагаа өргөснийхөө дараа Хиллари Клинтоны хувийн И-мэйл хаягийг шалгах тусгай баг гаргах уу. Халз мэтгэлцээний үеэр түүнийг шоронд хийж, шалгуулна хэмээн хатуухан ярьж байсан?**

-Би магадгүй өөрт тань түүнийг шалгаж, шоронд хорино гэж хэлж болно л доо. Гэхдээ энэ талаар ярихаас илүүтэй ажилдаа, эрүүл мэнддээ, улсын хил, цагаачлалын асуудал, цагаачлалын хуулийг илүү боловсронгуй болгоход л анхаарлаа төвлөрүүлэхийг хүсч байна.

# СӨРӨГ ХҮЧНИЙХЭН ПАК ГЫН ХЭГ ОГЦРУУЛАХАД ХАНГАЛТТАЙ ТООНЫ САНАЛ ЦУГЛУУЛЖЭЭ




Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Пак Гын Хэг албан тушаалаас нь түдгэлзүүлэх асуудлаар санал хураалт явуулахад /импичмент/ хангалттай тооны саналыг сөрөг хүчнийхэн цуглуулаад байна гэж импичментийг дэмжиж буй эрх баригч “Сэнури” намын парламент дахь бүлгийн хэвлэлийн төлөөлөгч мэдэгдлээ. Төлөөлөгч Хван Ён Чыл өчигдөр сэтгүүлчдэд мэдэгдэхдээ “Ерөнхийлөгч өчигдөр үг хэлсний дараа түүнийг огцруулахыг шаардаж буй хүмүүсийн шийдэмгий байдал суларч магадгүй гэж бодож байсан. Гэхдээ ийм юм болсонгүй. Өнөөдөр бүлгийнхэн хуралдаад өмнөх байр сууриа хэвээр үлдээлээ” гэв. Тус улсын парламентын 300 гишүүний наад зах нь 200 нь ерөнхийлөгчийг огцруулах тухай саналыг дэмжсэн тохиолдолд Пак Гы Хэг албан тушаалаас нь түдгэлзүүлэх юм. Түүнийг огцруулах асуудлаарх санал хураалтыг арванхоёрдугаар сарын 2-9-нд явуулахаар төлөвлөжээ. Ерөнхийлөгчийг огцруулахын тулд сөрөг хүчнийхэн эрх баригч "Сэнүри" намаас сонгогдсон 28 депутатын дэмжлэгийг авахад хангалттай юм. Харин парламент дахь Пакийг дэмжигчид "Ерөнхийлөгчийн саналыг анхааралтай судалж, засгийн эрхийг шилжүүлэх оновчтой төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй" гэж үзэж байна. Хамгийн боломжит хувилбар бол Пакийг ирэх оны дөрөвдүгээр сард огцруулж, зургадугаар сард сонгууль явуулах явдал юм гэж тэд тооцжээ. Харин сөрөг хүчний гурван том намаас сонгогдсон парламентын гишүүд үүнийг эрс эсэргүүцэж "энэ бол ард олныг хууран мэхэлж, албан тушаалаа хүлээлгэн өгөх хугацаагаа хойшлуулж байгаа хэрэг мөн" гэж дүгнэсэн байна. Тэд хамтарсан мэдэгдэл хийж "ямар нэгэн болзол нөхцөл тавилгүйгээр нэн даруй огцрохыг" Пакаас шаарджээ.

# “Goldman Sachs”-ын захирал асан Стив Мнучин Сангийн сайд болно

Хөрөнгө оруулалт, банк санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Goldman Sachs” компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Стив Мнучиныг АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Дональд Трамп Сангийн сайдаар томилж магадгүй байгаа тухай эх сурвалжууд мэдээлж байна. Д.Трампын сонгуулийн кампанит ажлын үеэр санхүүгийн асуудлыг хариуцаж байсан ноён С.Мнучиныг өнөөдөр АНУ-ын Сангийн сайдаар томилох бололтой. Мягмар гарагт Д.Трамп Эрүүл мэндийн сайдаар Том Прайсыг, Тээврийн сайдаар Элайн Чаог тус тус томилсон юм. Э.Чао бол Ерөнхийлөгч Жорж Бушийн засгийн газрын үед 2001-2009 онд Хөдөлмөрийн яамыг удирдаж байсан Митч Макконнеллын эхнэр юм. Тэрбээр АНУ-ын засгийн газрын гишүүнээр томилогдсон анхны ази гаралтай эмэгтэй /Тайваньд төрсөн/ ажээ. Харин одоо Д.Трамп Төрийн нарийн бичгийн дарга болон Батлан хамгаалахын сайдаар хэнийг томилохоо нухацтай бодож байна. Тэрбумтан, хөрөнгө оруулагч Уилбур Росс Худалдааны сайд болох магадлал өндөр байгаа юм.

MMINFO.

Тал нутгийн цахим мэдээлэл

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЖИЛД ХОЁР УДАА ЗОХИОН БАЙГУУЛДАГ

Н.БАТЗАЯА

*ЦЕГ-ын Зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу 13 аймагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг байгуулсан байна. Энэ тухай болон, мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар Мөрдөн байцаах газрын Хулгайлах гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Х.Буянтүмэнгээс тодруулллаа.*

**-Оны эхний 10 сарын байдлаар мал хулгайлах гэмт хэргийн статистик үзүүлэлт гарсан байх. Ер нь нөхцөл байдал ямар байна вэ?**

-Цагдаагийн байгууллага 2016 оны эхний 10 сард иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн тухай 32 мянган гомдол мэдээлэл хүлээж авсны 1400 нь мал хулгайлах гэмт хэрэгтэй холбогдолтой байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 26.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Оны эхний 10 сарын байдлаарх нийт хулгайн гэмт хэргийн 67.4 хувь нь нийслэлд, 32.6 хувь нь орон нутагт үйлдэгдсэн байна. 2015 оны мөн үед энэ төрлийн 1000 гэмт хэрэг бүртгэгдэж Мал хулгайлах гэмт хэргийг онцлоод авч үзвэл, сүүлийн гурван жил дараалан энэ төрлийн гэмт хэрэг буурсан эерэг үзүүлэлт гарч байгаа. Бид ч мал хулгайлах гэмт хэргийн эсрэг арга хэмжээнүүдээ явуулсаар байна. ЦЕГ-ын Зөвлөлийн хурлаар 13 аймагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дагнасан хэсгийг байгуулж, мэргэшсэн алба хаагчдыг томилон ажиллуулж байна. Ингэснээр илүү үр дүн гарна гэж харж байгаа.

**-Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх бүсийн зөвлөгөөнүүдээс гарсан шийдвэр хэр хэрэгжиж байна. Мал бүхий иргэдтэй хамтран ажилласнаар энэ төрлийн гэмт хэрэг буурах хандлага байна уу?**

-Жилдээ хоёр бүсэд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөгөөнийг зохион байгуулдаг. Энэ жил Говь-Алтай, Ховд аймаг болон Багануур дүүрэгт хийсэн. Аймгийн цагдаагийн газар, хэлтсүүд, тухайн орон нутгийн ИТХ, ГХУСЗ, иргэдийн төлөөллийг оролцуулан зөвлөгөөн зохион байгуулдаг. Уг зөвлөгөөнөөс гарсан үйл ажиллагааны чиглэл, бодлогын бичиг баримт зэрэг дээр үндэслээд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг явуулж байгаа. Тодорхой үр дүн гарч байна. Зөвлөгөөний үр дүнд хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгжүүдээс ирүүлсэнтэй материалтай танилцахад бүс нутагтаа нэлээн ахиц гарч байна. Мал хулгайлах гэмт хэрэг буурсан нь үр дүнгийн нэгэн илрэл. Цагдаагийн байгуулага, ялангуяа Мөрдөн байцаах газрын Хулгайлах гэмт хэрэг мөрдөх хэлтсээс "Малчин лавлах-109", "Тод сураг" сайт болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, худалдааны байгууллагуудтай хамтран ажилладаг. Нийслэлд мал, малын гаралтай түүхий эд борлуулдаг худалдааны төвүүдэд хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж байна.

**-Цагдаагийн байгууллагаас иргэдийн өмч хөрөнгийг хамгаалах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлууд хийж буй юм байна. Харин малчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хэрхэх шаардлагатай байна вэ?**

-Малын хулгайн гэмт хэрэг гараад байгаа үндсэн шалтгаан бол малчид малаа хариулахгүй байгаатай холбоотой. Хэрэв малчид малаа өдөр нь байнгын хариулгатай, шөнийн манаатай байлгавал малын хулгайн гэмт хэрэг огцом буурах, гарахгүй байх шалтгаан нөхцөл бүрдэх юм. Мөн алдуул болон олдсон малын тухай мэдээллийг цагдаагийн байгууллага, "Малчин лавлах-109", "Тод сураг" сайт руу өгч тухай бүрт өгөх хэрэгтэй. Ингэвэл олдсон малыг эрэн сураважлах, хохирогчийг олох ажилд маш их үр дүн гарахаар байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛЛАА

Иргэд хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан түлээний мод бэлтгэх нь ихэссэн гэнэ. Үүнтэй холбогдуулан бэртэж, гэмтэх тохиолдол гарах болжээ. Өчигдөр гэхэд 52 настай ГТуулын бургасанд мод бэлтгэж байгаад толгойдоо хүнд бэртэл авсан байна. Тодруулбал, өчигдөр "ГССҮТөвд модноос унаж гэмтсэн хүн ирж хэвтлээ" гэсэн мэдээллийг цагдаагийн газарт иржээ. Дуудлагын дагуу шалгахад, Био комбинатын Туул голын бургасанд мод бэлтгэж байгаад модноос унаж, толгойдоо гэмтэл авсан аж. Улмаар ГССҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа гэнэ. Тус хэргийг Хан-Уул дүүргийн цагдаагийн II дугаар хэлтэс шалгаж байгаа ажээ. Тиймээс цагдаагийн газраас иргэдэд хууль бусаар мод бэлтгэхгүй байхыг анхааруулллаа

## Маршал Г.К.Жуковын хөшөөнд цэцэг өргөнө

Энэ жил ЗХУ-ын маршал Г.К.Жуковын мэндэлсний 120 жилийн ой тохиож буй. Ойн хүрээнд Улаанбаатар хот дахь Г.К.Жуковын хөшөөнд цэцэг өргөх ёслол өнөөдөр болох юм байна. Энэхүү ёслолын үйл ажиллагаанд ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд И.К.Азизов, Беларусь улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд С.В.Чепурной, Монгол Улсын Батлан хамгаалахын дээд удирдлагууд оролцох ажээ. Цэцэг өргөснийхөө дараа ёслолын ажиллагаа Г.К.Жуковын музейд үргэлжлүүлэн явагдана хэмээн ОХУ-ын ЭСЯ-наас мэдээллээ. Цэцэг өргөх ёслолын ажиллагаа 11:00 цагт эхлэх юм байна.

## Өвөрхангай аймагт мотоциклийн хулгай ихэссэн гэв

Өвөрхангай аймагт мотоциклийн хулгайн гэмт хэрэг өссөн байна. Тус аймаг дахь Цагдаагийн газарт оны эхний есөн сарын хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 40 хувийг хулгайн гэмт хэрэг эзэлжбайгаагаасмотоциклийн хулгайн гэмт хэрэг 11.8 хувийг нь эзэлж байгаа талаар мэдээллээ. Албаны хүний ярьж байгаагаар 17-35 насны эрхэлсэн тодорхой ажилгүй этгээдүүдашиголох,шунахайн сэдэлтэйгээр хулгайн гэмт хэрэг үйлдэж байгаа аж. Энэ нь нийгэм эдийн засгийн байдал тогтворгүй байдалтай нэг талаар холбоотойг ч дурдсан юм. Нөгөө талаар ид ажил хөдөлмөр эрхлэх насны залуус амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор хулгайлах төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа нь тэдний ухамсар доройг харуулж байна гэв. Мотоциклийн хулгайн гэмт хэргийг илрүүлэлт 53.8 хувьтай байгаа гэнэ. Хэрэг илрэхгүй байх шалтгаан нь иргэд худалдаж авсан тээврийн хэрэгслийн гаалийн бичиг,улсындугаарыгаваагүй, хариуцлагагүй байдалтай холбоотой аж. Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газраас хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Олон нийтийн цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Арвайхээр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны арваннэгдүгээр сарын 18-ны өдрийн урамшуулалт эргүүл ажиллуулах тухай 34 дүгээр тогтоолын дагуу урамшуулалт эргүүл ажиллуулж байгаа юм. Мөн Арвайхээр сумын иргэн олон нийтийн зөвлөлийн гишүүдийг баг тус бүр дээр ажиллуулж буй юм байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд 10 олон нийтийн цагдаагийн ажилтан үүрэг гүйцэтгэж байгаагаас зургаа нь Арвайхээр суманд ажиллаж, иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцон, ажиллаж байна.

## Ирвэсний зулзага өлсч үхсэн тохиолдол гарчээ

Манай улсын нэн ховордсон амьтны тоонд цаст уулын цагаан бар гэлцдэг ирвэс ордог билээ. Дэлхий дээр ердөө 3500 орчим цоохор ирвэс байдгаас 1000-1200 нь манай оронд амьдардаг. Гэвч хулгайн анчид болон уул уурхай, алтны компаниудаас болж ирвэсний тоо толгой цөөрч, үр удам нь устах аюул тулгараад буй. Тэгвэл хоолгүйн улмаас ирвэсний зулзага үхсэн хэрэг гарчээ.

Тодруулбал, Ховд аймгийн Дуут сумын малчин малаа хариулж яваад ирвэсийн хоёр зулзага үхсэн байхыг олж мал эмнэлгийн газарт хүргэжээ. Лабораторийн шинжилгээгээр хоёр зулзагад өвчний шинж тэмдэг илрээгүй бөгөөд өлсөж үхсэн гэх дүгнэлт гарсан байна. Дашрамд сонирхуулахад, ирвэс дэлхийн 12 улсад нутгалдгаас манай улсын Монгол-Алтай, Говь-Алтай, Алтай, Өвөрговийн уул нуруud зэрэг 90-130 мянган км квадрат нутагийг эзлэн тархсан. Манай улс ирвэсийн тоо толгойн хэмжээгээр дэлхийд Хятадын дараа хоёрт ордог. Цоохор ирвэс Монгол орны "Улаан ном", Вашингтоны конвенцын нэгдүгээр хавсралтад орсон байдаг ажээ.

## Нэр шилжүүлэв

Г.Нямгэрэлийн эзэмшлийн 9011341102 улсын бүртгэлийн, 5586356 регистрийн дугаартай "Тэнүүн аялгуу" компанийн гэрчилгээг "Гоё фасад" ХХК болгон өөрчилж Ц.Баттулгад эзэмшүүлэх эрхийг шилжүүлэв.

## Хүчингүйд тооцов

Сүхбаатар Дүүргийн 71-р сургуулийн 2007013 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тул хүчингүйд тооцов

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Ү-2205016024 Улсын бүртгэллийн дугаартай байрны гэрчилгээг гээсэн тул хүчингүй тооцов.

## Оюутнууд эрүүл мэндийн даатгалдаа идэвхтэй хамрагдаж эхэлжээ

Улс эх орны хөгжил, бүтээн байгуулалтыг тодорхойлох хүмүүс бол оюутан залуучууд. Гэтэл тэдний өмнө цөөнгүй асуудал тулгарч байгаагийн нэг нь эрүүл мэндийн байдал юм. Учир нь сүүлийн жилүүдэд оюутан, залуучуудын дунд хоол боловсруулах эрхтний өвчлөл болон бэлгийн замаар халдах халдварын тоо эрс нэмэгджээ. Тиймээс өсвөр үе, залуучууд руу чиглэсэн эрүүл зан үйл, хэв маягийг хэвшүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зайлшгүй шаардлага тулгарч буй. Иймд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санаачилгаар Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын Залуучуудын холбоо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монголын Оюутны холбоо хамтран "Эрүүл ирээдүйн төлөө хамтдаа" аяныг энэ өдрүүдэд зохион байгуулж байна. Аяны хүрээнд МУИС, МУБИС, ХААИС, ШУТИС, "Их засаг", "Этүгэн", "Монголын Үндэсний их сургууль", "Олон Улсын Улаанбаатар Их сургууль", "Мандах бүртгэл" дээд сургуулийн оюутнуудад холбогдох мэргэжилтнүүд эрүүл мэнддээ хэрхэн анхаарах, БЗХӨ-ний эрсдлээс урьдчилан сэргийлэх болон Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар ямар ач холбогдолтой болохыг сурталчлан таниулж, зөвлөгөө мэдээлэл өгчээ. Тиймээс ч оюутан, залуус эрүүл мэндийн даатгалдаа идэвхтэй хамрагдаж эхэлсэн гэнэ. Дашрамд дуулгахад, Эрүүл мэндийн даатгалд хамрагдахдаа оюутнууд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэг хувьтай тэнцэх буюу 1920 төгрөгийг төлдөг бөгөөд энэ нь жилд 23040 төгрөгөөр хоёр сая төгрөгтэй тэнцэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хуримтлагддаг байна.

## Хот тохижилтын газрын 200 ажилчинд дулаан хувцас бэлэглэлээ

Нийслэлд их хэжээний цас орохтой зэрэгцээд "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГазрын ажилчид цаг наргүй ажилладаг. Нийслэлийн оршин суугчдыг аюулгүй орчинд амьдруулахын төлөө зүтгэж буй Хот тохижилтын газар" ОНӨААТҮГазрын ажилчдад иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, албан байгууллага, сайн дурынхан ч уг ажилд идэвхи санаачилгатай оролцож, тус тусын хувь нэмрээ оруулсаар байна. Тухайлбал, үслэг эдлэлийн үндэсний үйлдвэрлэгч "Мастер додо" компанийн хамт олон Нийгмийн хариуцлагын хүрээнд "Хот тохижилтын газар"-ын олон цагаар гадаа хүнд хүчир ажил хийж байгаа зам талбайн үйлчлэгч, ачигч зэрэг 200 гаруй ажилчдад өөрсдийн үйлдвэрлэсэн тарваганы арьсан нуруувч, өвдгөвч, зузаан ноосон өмд, ажлын бээлий, ноосон бээлий, оймс тэргүүтэй бүтээгдэхүүнийг бэлэглэсэн байна. Ангын арьсан эдлэл, үслэг эдлэлийн үйлдвэрлэл нь оёж урлахад хэцүү, мэргэжил туршлага болоод технологи өндөр шаарддаг, үнэ өртөгийн хувьд багагүй хэдий ч нийслэлчүүдийнхээ сайн сайхны төлөө өдөр шөнөгүй ажиллаж байгаа зам талбайн үйлчлэгчдийг халуун дулаан байгаасай гэсэн сэтгэлээр "Мастер Додо" компанийхан уг ажлыг санаачилжээ.

PHOTO NEWS






Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*Сүхбаатар дүүргийн V дугаар хороо, VI дугаар сургуулийн гаднах хоккейн талбайн нээлт өчигдөр Уг талбайг дүүргийнхээ хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулжээ. Хоккейн талбай нь олон улсын стандартад нийцсэн, өвөл ашиглахаас гадна бусад улиралд өөр төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулах боломжтой юм. Спорт сонирхогчид, иргэд, хүүхэд багачууд хоккейн талбайтай болсондоо баярлаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ өвлийн спорт, тэр дундаа хоккей нь хүүхэд багачуудыг тэсвэр хатуужилтай болгох багийн спортыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах бодит ажил боллоо гэдгийг онцолж байлаа.*

ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# АРИЛЖААНЫ БАНКУУДТАЙ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Н.БАТЗАЯА

Манай улсад дундаж амьдралтай айл өрхийн хүүхдүүд дээд боловсрол эзэмшинэ гэдэг амаргүй даваа. Эцэг, эхийнх нь цалинг хэд нугалсан их, дээд сургуулийн сургалтын төлбөрөөс болоод сурах хүсэл байсан хэдий ч сургуульд суралгүй өнгөрөх залуус олон. Тэгвэл цаашид санхүүгийн хүндрэлээс болж өөрийн хүсэл мөрөөдлөө орхих хэрэггүй боллоо. Учир нь удаан хүлээлгэсэн оюутны сургалтын төлбөрийн зээлийн гэрээг өчигдөр БСШУСЯ арилжааны банкуудтай байгууллаа. Гэрээ байгуулах үйл ажиллагаанд БСШУСЯ-ны дэд сайд Ё.Отгонбаяр, арилжааны банкны төлөөлөл болон их сургуулийн төлөөллүүд оролцсон. Уг ажиллагааг нээж, БСШУСЯ-ны дэд сайд Ё.Отгонбаяр "Монгол Улсын Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт оюутны сургалтын төлбөрийн дарамтгүй болгох чиглэлийн арга хэмжээ авахаар заасан. Энэ бодлогын хүрээнд УИХ-аас хуулийн төслийг дэмжиж, улсын төсөвт санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан.

Энэ хүрээнд засгийн газраас оюутны хөгжлийн зээл олгох журмыг баталсан. Өнөөдөр бид оюутны хөгжлийн зээл олгох арилжааны банкуудтай гэрээ байгууллаа. БСШУСЯ-аас Засгийн газрын хөтөлбөрт заасан их, дээд сургуулийн оюутнуудыг сургалтын төлбөрийн дарамтгүй болгох ажлыг бодит болгох ажил өнөөдрөөс эхэлж байна. Энэ оюутнуудын хөгжлийн зээлийн Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн оюутнуудад олгоно. Тэгэхдээ тодорхой боломж, нөхцөлтэйгээр олгох юм. Энэ үйлчилгээ бий болсноор оюутнууд суралтын төлбөртөө санаа зоволтгүй амжилттай суралцах, цаашид ажилтай орлоготой болгох хариуцлагыг нь нэмэгдүүлэх, өрхийн санхүүгийн зардлыг бууруулж амьжиргааг дэмжихээс гадна дээд боловсролын сургуулиудын өрсөлдөөн нэмэгдэж, сургалтын чанар сайжрахад чухал ач холбогдол үзүүлнэ гэж бодож байна" гэв. Уг "Оюутны хөгжлийн зээл"-ийн үйлчилгээ бий болж байгаа нь оюутан суралцагчдыг сургалтын төлбөрийн дарамтгүйгээр амжилттай суралцах, төгсөөд ажилтай, орлоготой болох хариуцлагыг бий болгох, өрхийн санхүүгийн зардлыг бууруулж, амьжиргааг нь тэтгэхээс гадна дээд боловсролын сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой байна. Тус зээл нь Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус өмчийн бүх их, дээд сургууль, коллежийн оюутан бүрт нээлттэй ажээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Суралцагч сургуулиа төгссөний дараа, ажил хөдөлмөр эрхэлсэн цагаасаа эхлэн төлбөрийг төлөх нэн тааламжтай нөхцөлтэй, зээлийн хүүгийн дарамтгүй, хамгийн бага хүүтэй хөгжлийн зээл байх юм. Мөн "Оюутны хөгжлийн зээл"-ийг "Төрийн банк", "ХААН банк", "Голомт банк", "Улаанбаатар хотын банк", "ХАС банк", "Капитрон банк"-наас авах боломжтой юм байна. Энэхүү гэрээг байгуулснаар ирэх долоо хоногийн даваа гарагаас эхлээд оюутнуудад сургалтын төлбөрийн зээлийг олгож эхлэх гэнэ. Ингэхдээ Боловсролын зээлийн сангаас гурав болон түүнээс дээш хүүхэд нь дээд боловсролын сургалтын байгууллагын баклаврын сургалтад суралцаж байгаа өрхийн нэг хүүхдэд сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг олгох ажээ. Энэ үеэр гэрээ байгуулах үйл ажиллагаанд оролцсон холбогдох албаны хүмүүстэй цөөн хором ярилцлаа.

> ...Эхний судалгаанаас харахад, 70 очим мянган оюутан зээл авна гэсэн дүн гарсан. Өмнөх хөтөлбөр бол Засгийн газрын 19 дүгээр тогтоолын хүрээнд зээл олгогдож байсан. Тэр хөтөлбөр бол сургалтын төлбөрийн зээлийг бүтэн өгдөггүй, 350-650 мянган төгрөгийн зээлийг дипломыг нь барьцаалж өгдөг байсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд жилд 3500-3800 оюутан зээл авч байсан...

### Ё.Отгонбаяр: Ирэх долоо хоногоос сургалтын төлбөрийн зээл олгож эхэлнэ

*/БСШУСЯ-ны дэд сайд/*

-Өнөөдөр гэрээнд гарын үсэг зурлаа. Тэгэхээр ирэх долоо хоногийн нэг дэх өдрөөс эхлээд олгогдож эхэлнэ. Журмандаа гурван төрлийн зээл олгохоор заасан байгаа. Хүү хөнгөлөх зээл гэж бий. Жишээлбэл, хүүхдийнхээ төлбөрийг төлөхийн тулд эцэг, эх нь цалингаасаа өндөр хүүтэй зээл авсан байвал тэр зээлээ сургалтын зээлээр сольж болно. Мөн голч дүн нь хоёроос дээш байгаа тохиолдол богино хугацааны зээлд хамрагдах боломжтой. Харин нэгдүгээр курст элсэж буй хүүхдүүд ЭЕШ-д 400-ээс дээш оноо авсан тохиолдолд зээл авч болно. Хэрэв голч дүн гурваас дээш, ЭЕШ-д 600-аас дээш оноо авсан бол урт хугацааны буюу 10 хүртэлх жилийн зээлд хамрагдаж болно. Одоо арилжааны банкууд зээлийн хүсэлтээ авч эхлэх учраас одоогийн байдлаар хэчнээн хүүхэд хүсэлт гаргаад байгаа талаар мэдэх боломжгүй. Яах вэ, бид урьдчилсан байдлаар 70 мянга гаруй оюутан зээлд хамрагдана гэж тооцоолсон. Гэхдээ энд бас нэг зүйл нэмж хэлье. Хамтран зээлдэгч гэж гарч ирж байгаа шүү дээ. Оюутан өргөдлөө гаргаад хамтран зээлдэгч орлогын эх үүсвэрээ банкиндаа нотлоод зээлээ авч болох юм. 2016 оны төсөвт 90 тэрбум төгрөг төсөвлөсөн байсан. 2017 оны төсөвт 110 тэрбум төгрөгийн төсөв бий. Гэхдээ үүнийг нэг хичээлийн жилийн төсөв гэж ойлгож болохгүй. Учир нь оны дараа ирэх хичээлийн жил эхэлнэ. Бид ажилд орсны дараа төлөөд явах боломжтой зээлийн нөхцөл бий. Энэ зээлийг авсан хүүхэд өөрөө ажилд орох ёстой л болж байгаа юм. Зээл эргэн төлөлттэй явагдана. Энэ эргэн төлөлт нь буцаад боловсролын зээлийн сандаа хуримтлал үүсгэх юм. Тэр хуримтлалаараа 2020 оноос хойш уг зээлийн сан өөрийгөө санхүүжүүлээд явах боломжтой.

### П.Лхагвасүрэн: Боловсролын зээлийн санд 13 мянган оюутны диплом хадгалагдаастай байна

*/Боловсролын зээлийн сангийн захирал/*

-Юун түрүүнд Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд энэ жилийн хувьд 90 тэрбум төгрөг, ирэх жил 110 тэрбум төгрөгийг төсөвт суулгасан. Ер нь бид оюутан залуусаас эхний ээлжинд судалгаа авч байна. Эцсийн байдлаар тэр хэмжээний оюутан авна гэж хэлж болохгүй байна л даа. Эхний судалгаанаас харахад, 70 очим мянган оюутан зээл авна гэсэн дүн гарсан. Өмнөх хөтөлбөр бол Засгийн газрын 19 дүгээр тогтоолын хүрээнд зээл олгогдож байсан. Тэр хөтөлбөр бол сургалтын төлбөрийн зээлийг бүтэн өгдөггүй, 350-650 мянган төгрөгийн зээлийг дипломыг нь барьцаалж өгдөг байсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд жилд 3500-3800 оюутан зээл авч байсан. Тэр үед 3.4 тэрбум төгрөгийн зээлийг олгодог байсан. Одоогийн байдлаар боловсролын зээлийн санд 13 мянга орчим оюутны диплом хадгалагдаастай байж байна.

### С.Нямдаг: Монголын боловсролын системд цоо шин зүйл орж ирлээ

*/ "Этүгэн" их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/*

-Миний бодлоор Монголын боловсролын системд энэ зээлийн хэмжээ, зээлийн төлөлттэй холбоотой асуудал орж ирсэн нь цоо шинэ зүйл болно. Оюутан зээл авах, гараад ажлын байртай болох уу, эцэг, эхчүүд зээлийг нь төлж өгч чадах уу гээд олон асуудал гарч ирнэ. Үүнд их, дээд сургуулийн удирдлагууд маш их анхаарал тавих хэрэгтэй. Хэрвээ хариуцлагагүй хандвал сургууль өөрөө асуудалд унана. Таван хувийн эрсдэл хүлээхээр болж байна. Тэр утгаараа авч үзвэл сургууль, эцэг,эх, оюутан гээд сургалтад оролцож буй бүх тал хариуцлагатай хандах цоо шинэ үзэгдэл болно гэж харж байна. Хуучин засгийн мөнгийг зүгээр шахуу авдаг байсан бол одоо тодорхой хэмжээнд хариуцлага хүлээдэг боллоо.

### Д.Бадрал: Банкуудад ачаалал үүсэхгүй

*/Голомт банк/*

-Өмнө нь банкинд олгогдож буй нийт зээлийн 2-3 хувь нь сургалтын зээл байсан бол энэхүү гэрээг байгуулснаар илүү нэмэгдэнэ гэсэн үг. Банкууд дээр зээлийн эцэг, эхийнхээ цалингийн зээл болон эрхийн зээлийн нөхцөлөөр шийдэж явсан. Энэ нь бол "Голомт" банкны хувьд ачаалал болохгүй. Бид хөдөө орон нутгийн 100 орчим салбараар үйлчилгээ үзүүлэх боломжтой. Зээлийн эрсдлийг банк хариуцаж байгаа. Зээлийн эрсдлээ барьцаа авч болно, авахгүй ч байж болно гэж үзэж байгаа л даа. Энэ нь тухайн зээлдэгчийн зээлийн түүх, нийгэмд эзэлж байгаа зээл төлөх чадвар зүйлээс хамаарна. Харин урт хугацааны зээл дээр эхний зургаан жил төгстөл хүүгээ аваад явна. Ажлын байран дээр гарсных нь дараа үндсэн зээлээ аваад явах болохоор эрсдэл багатай байна байх.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Хан-Уул дүүрэгт 240 хүүхдийн цэцэрлэг нээгдлээ

Хан-Уул дүүргийн 16-р хороонд шинээр баригдсан цэцэрлэгийн нээлт өчигдөр боллоо. Тус цэцэрлэгийн нээлтийн ёслолд ИТХ-ийн дарга Б.Цэрэн Нийслэлийн Боловсролын газрын санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Энхтөр, Хан-Уул дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Булган, Боловсролын хэлтсийн дарга С.Эрдэнэчимэг, 16 дугаар хорооны Засаг дарга С.Сарангуа, 243 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Саранцэцэг болон бусад төлөөлөгчид, сурагчид оролцлоо. Нээлтийн арга хэмжээг ИТХ-ийн дарга Б.Цэрэн нээж хэлсэн үгэндээ "Цэцэрлэгийн асуудал бол улсын нэн тэргүүний асуудал байдаг. Өнөөдөр бид цэцэрлэгийн хүртээмж муу байгааг мэднэ. Харин ийм үед тус цэцэрлэг ашиглалтад орж, нээлтээ хийж байгаад баярлаж байна. Нийт сурагчид маань зөв, шударга сайн боловсролтой иргэн болж төлөвшихийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье" хэмээлээ. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгаар баригдсан тус цэцэрлэг нь 10 бүлгийн 240 ор бүхий хүчин чадалтай бөгөөд одоогийн байдлаар 360 хүүхэд хүмүүжиж, 38 багш ажилчид ажиллаж байна. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1.5 тэрбум өртөг бүхий энэхүү цэцэрлэгийн барилгын ажлыг "Морин сувд" ХХК амжилттай гүйцэтгэж хүлээлгэн өгсөн бөгөөд тус цэцэрлэгт БСШУСЯ - 43 сая, Хан-Уул дүүргийн ЗДТГ 29 сая, эцэг эх, бусад байгууллага 13 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж тохижуулсан байна.

## Шилдэг залуу судлаачдад судалгааны грант олгов

"Хүрэлтогоот залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал"-ыг жил бүр Боловсрол Соёл, Шинжлэх Ухааны Яам, Шинжлэх Ухааны Академи, "Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо", "Шинжлэх Ухаан Технологийн Сан", их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд хамтран зохион байгуулж ирсэн. Тус эрдэм шинжилгээний бага хурал нь нэг талаас эрдэмтдийн залгамж халааг бэлтгэх, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, харилцан туршлага судлах нөхцлийг бүрдүүлэх нөгөө талаас судалгааны ажлын үр дүнгээ өргөжүүлэн төр, хувийн хэвшил болон олон нийтэд сурталчилан таниулах ач холбогдол бүхий уламжлалт ажлуудын нэг билээ. Монголын залуу эрдэмтэн судлаачдын "Хүрэлтогоот-2016" эрдэм шинжилгээний бага хуралд ахмад эрдэмтэн, багш нар уригдаж, 500 гаруй судлаач, эрдэм шинжилгээний ажилтан бүтээлээрээ оролцож, амжилттай зохион байгуулагдлаа. Тус эрдэм шинжилгээний бага хурал нь нийгэм-хүмүүнлэг, геологи, газар зүй, байгалийн ухаан, техник технологи, биологи, хөдөө аж ахуй, анагаах ухааны салбар гэсэн чиглэлээр илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг 12 залуу судлаач тус бүрт БСШУС-ын сайдын нэрэмжит дөрвөн сая төгрөгийн судалгааны Грантыг олгожээ. Залуу судлаачид БСШУС-ын сайдын нэрэмжит судалгааны Грантыг цаашид судалгаагаа хөгжүүлэх, онол, туршилт, үйлвэрлэлийн үр дүнгээ бататгах, өөрийн судалгааны чиглэлээр олон улсын хурал, семинарт оролцон туршлага судлах зэрэгт зориулан ашигладаг байна.

## Гар зургийн уралдааны тэргүүн байрын эзэд тодров



Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн дунд зохион байгуулсан "Миний ертөнц" сэдэвт гар зургийн уралдаанд байр эзэлсэн бүтээлийн эздэд шагнал гардуулах үйл ажиллагаа өчигдөр БСШУСЯ-нд боллоо. НҮБ-аас жил бүрийн арванхоёрдугаар сарын 03-ны өдрийг "Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр" болгон дэлхий нийтээр тэмдэглэдэг уламжлалтай. Тус өдрийг угтан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дуу хоолой, хүсэл мөрөөдлийг сонсох, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, тэдний өөртөө итгэх итгэлийг нэмж, урамшуулах зорилгоор БСШУСЯ, ХНХЯ, ЖАЙКА-тай хамтран "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлж байгаа юм. Энэ хүрээнд нийслэлийн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн дунд "Миний ертөнц" сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж шалгаруулан дүгнэлээ. Тус уралдааныг нийслэлийн есөн дүүргийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" болон зургаан тусгай сургуулиар дамжуулан зохион байгуулжээ. Улмаар эдгээр байгууллагаас шалгаруулсан нийт 143 бүтээлийг БСШУСЯ, ХНХЯ-ны, "Монголын хүүхдийн ордон"-ы зургийн багш "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй баг шүүж, тэргүүн байр нэг, дэд байр нэг, гутгаар байр хоёр, тусгай байранд найман бүтээлийг шалгаруулсан.

# ЭРҮҮЛ МЭНД

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# МОНГОЛЫН ХҮНИЙ ИХ ЭМЧ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨВ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Зөвлөгөөнийг нээж, тус сургуулийн захирал Г.Батбаатар "Бид зорилгоо тодорхойлсон, хийх ажлаа төлөвлөсөн, гарах үр дүнгээ мэдэрсэн, хүрэх хугацаагаа хүртэл тавьсан. Бидний хийх ажил тов тодорхой. Бидний ганц хүсэл бол хөгжсөн улс орны хүний их эмч бэлтгэдэг эрүүл мэндийн дээд боловсролтой боловсон хүчин, тусгай мэргэжилтэн бэлддэг тэр сургуулийн төвшинд ярьж, хийдэг зүйлийг нь хийх, боддог зүйлийг бодож, бичдэг юмыг нь бичихийг л хүссэн. Үүний анхны шаардлага бол энэ хөтөлбөрөө олон улсад хүлээн зөвшөөрүүлэх магадлах ажил байсан юм. Энэ хамт олон, эрдэмтэн профессорууд нэг зүг харж чадсан учраас бид маш богино хугацаанд амжилттай хийж чадлаа. Олон улсын магадлан итгэмжлэлийг хүмүүс янз бүрээр хүлээж авч байгаа.

Зарим хэсэг нь төгсөөд манай диплом гадаадад хүлээн зөвшөөрөгддөг юм. Би гадаад улс оронд ажиллахад саадгүй боллоо гэж байна. Энэ хэсэг нь мөн үү гэвэл мөн. Гэхдээ энэ бол магадлан итгэмжлэлийн үндсэн ач холбогдлыг тодорхойлох маш жижиг хэсэг нь. Үндсэн хэсэг нь юу вэ гэвэл ялангуяа Европын холбооны улс оронд хүний их эмчийг бэлтгэх хөтөлбөр нь боломжийн хөтөлбөр байна, түүнийг бэлтгэж байгаа багш бэлтгэгдсэн байна, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчинг нь биелүүлсэн сургууль байна гэдэг үүднээс магадлан итгэмжлэл олгосон болов уу гэж ойлгодог. Гэхдээ энэ шалгуур зөвхөн эхний шалгууруудад хүрч байна гэж ойлгосон. Бидэнд цаашид хийх зүйл маш их байна. Энэ зүйлийг бид төлөвлөсөн. Хариуцсан хүн нь бий. Үйлчлэх хугацаатай. Үр дүнг нь ч бид мэдэж байгаа учраас амжилтад хүрнэ гэдэгт би итгэж байна" гэв. Тус сургууль нь 1942 онд Монгол Улсын их сургуульд Хүн эмнэлгийн Факультет байгуулагдсанаас хойшхи 70 гаруй жилийн хугацаанд Хүний их эмч бэлтгэх хөтөлбөрийг үе шаттайгаар шинэчлэн боловсронгуй болгож иржээ. Энэ хугацаад 2011, 2016 онуудад Сургалтын хөтөлбөрөө Үндэсний хэмжээнд амжилттай магадлан итгэмжлүүлж, сургалтаа явуулж байгаа аж. Мөн энэ жил АШУҮИС-ийн хүний их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг БСШУСЯ, Боловсролын газар, Дээд боловсролын хэлтэс, Боловсролын магадлан итгэмжлэлийн Үндэсний зөвлөл, Азийн хөгжлийн банкны Дээд боловсролын шинэчлэл төслийн дэмжлэгтэйгээр ХБНГУ-ын ASIIN олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, магадлан итгэмжлүүлснээр олон улсын төвшинд хүрсэн сургалт явуулдаг болохыг баталгаажуулж, гэрчилгээгээ хүлээн авч байгаа юм байна.

Энэ үеэр Анагаах ухааны доктор, профессор Д.Мягмарцэрэн "Энэ хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээр оюутан, сурагч, төгсөгчид, эмч нар маань олон улсад хүлээн зөвшөөрөгдөж байгаа гэсэн үг. Энэ бол манай сургуулийнхны олон жилийн хүч хөдөлмөрийн үр дүн, бахархал болж байна" гэв. Их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрт олон улсын гэрчилгээ олгосноор гадны оронд суралцах, гадаад харилцаа дээшлэх гэх мэтчилэн боломж нээгдэж байгаа талаар сургуулийн багш нар онцолж байв. Тодруулбал, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, гадны оронд кредит болон оюутан солилцоо хийх гадны оронд төгсөлтийн дараах сургалтаар мэргэжил дээшлүүлэх, гадны оронд урт, богино хугацааны сургалтад хамрагдах зэрэг боломж нээгдэж байгаа ажээ. Олон улсад магадлан итгэмжлэгдсэний гэрчилгээ хүлээн авах үеэр тус сургуулийн багш болон оюутнуудтай уулзаж, сэтгэгдлийг нь сонссон юм.

## Х.Батсайхан: Магадлан итгэмжлэх долоон хөтөлбөрийн нэгэнд шалгарч, гэрчилгээ авсан

*/Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн дэд дарга/*

-Өнөөдөр маш сайхан баяртай үйл явдал тохиолдож байна. Энэ бол манай БСШУСЯ, Азийн хөгжлийн банкны дэргэдэх Дээд боловсролыг шинэчлэх төсөл, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөс хэдхэн сарын өмнө олон улсад магадлан итгэмжлүүлэх долоон хөтөлбөр, дотоодод магадлан итгэмжлүүлэх 20 хөтөлбөрт санхүүжилтийг батлан гардуулж байсан өдрөөс хэдхэн сарын дараа болж байгаад бид маш баяртай байна. ХБНГУ-ын инженер мэдээлэл, байгалын ухаан, математикийн мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх ASIIN байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн АШУҮИС тэр дундаа Анагаах ухааны сургуулийн хамт олонд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн өмнөөс баяр хүргэе. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй боловсролын шинэчлэл төслийн хүрээнд долоон хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд хамгийн анхны магадлан итгэмжлэлийг АШУҮИС шалгарч, өнөөдөр гэрчилгээгээ авч байна. Дээр дурдсан долоон хөтөлбөрийн дөрөв нь Герман улсын ASIIN байгууллагаар магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан.

## Б.Оюунгоо: Гадаадын улс орнуудад ажиллах боломж нээгдэж байна

*/АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга/*

-Манай сургуулийн сургалтын бодлогын хүрээнд хийж байгаа маш том ажлуудын нэг нь магадлан итгэмжлэл. Магадлан итгэмжлэл маань байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн гэсэн хоёр төрөл байгаа. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл дотроо олон улсын болон үндэсний гэж ангилагдана. Энэ удаад манай сургуулийн Хүний их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдлээ. Хүний их эмч бэлтгэх хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээр манай сургуулийн суралцагч оюутнууд, төгсөгчид, эмч нар олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, гадаадын улс орнуудад ажиллах боломж нээгдэж байна. Зарим оронд манай төгсөгчдийг хүлээн зөвшөөрдөггүй байсан бол одоо тийм асуудалгүй боллоо. Тэгэхээр зарим тохиолдолд манайхан буруу ойлгочихдог. Төгсөөд шууд хаана ч хамаагүй ажиллах эрхтэй боллоо гэж ойлгодог. Гэтэл дэлхийн аль ч улс оронд лицензийн шалгалт өгч байж эмчээр ажиллах эрхээ олж авдаг.

## Г.Анхболд: Төгссөний дараа урт, богино хугацааны сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлэх боломж бүрдсэн

*/АШУҮИС-ийн зургадугаар курсийн оюутан/*

-Манай сургууль олон улсад магадлан итгэмжлэгдсэнээр оюутан бидэнд маш их ач холбогдолтой. Тухайлбал, бид төгссөний дараах урт болон богино хугацааны сургалтад хамрагдаж, цаашид магистр, докторын шатны сургалтад дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад суралцах боломжтой болж байна. Түүнээс гадна суралцаж байх хугацаандаа оюутан солилцооны хөтөлбөрүүдэд хамрагдаж болдог. Би Япон улсын Токүшима их сургуульд оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдаж байсан. Сургууль маань магадлан итгэмжлэгдсэн болохоор үзэж байгаа хичээл, дадлага туршлага нь олон улсын сургуулиас зөрдөггүй. Тэгэхээр кредит цагийнхаа хичээлийг энд тооцуулаад дэлхийн хөгжилтэй орнуудад дадлага хийгээд мэргэшээд явах нь илүү үр дүнтэй байдаг. Одоо бүр сайхан болж байна. Бид сургуулиа төгсөөд олон улсад гарч ажиллах боломж бүрдлээ.

## Д.Номин-Эрдэнэ:Гадаад ажиллах боломжийг сургууль маань нээж өглөө

*/АШУҮИС-ийн тавдугаар курсийн оюутан/*

-Сургууль маань олон улсад магадлан итгэмжлэгдэж буйд баяртай байна. Бид суралцах хугацаандаа гадаадын нэр хүндтэй их, дээд сургуульд оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжтой болсон. Мөн төгссөний дараа урт, богино хугацааны сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлэх боломж бүрдэж байна. Миний хувьд Герман улсад магистар, докторын сургалтад хамрагдах хүсэлтэй байдаг. Энэ боломжийг маань сургууль нээж өгч байгаад баяртай байна.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## ХСҮТ-ийг Ж.Чинбүрэн, ГССҮТ-ийг Т.Мөнхсайхан удирдахаар боллоо

Эрүүл мэндийн сайдын тушаалаар Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Ж.Чинбүрэнг, ГССҮТ-ийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Т.Мөнхсайхан нарыг тус тус томилжээ. ЭМЯ-наас Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатаар ахлуулсан комисс ажлыг нь хүлээлцүүлж, тамга тэмдгийг нь гардуулж өгсөн юм. Дашрамд дуулгахад, Ж.Чинбүрэн, Т.Мөнхсайхан эмч нарын хувьд хоёулаа байгууллагадаа олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад ийнхүү хамт олон дотроосоо томилогдож байгаа аж.

Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээ томилогдсон Ж.Чинбүрэн нь 1997-1998 онд Анагаах Ухааны Хүрээлэнд туслах ажилтан, 1998-2007 онд Хавдар судлалын үндэсний төвд Мэс заслын эмч, 2008 оноос одоог хүртэл ХСҮТ-д, Элэг цөс нойр булчирхайн Мэс заслын тасгийн эрхлэгчээр ажиллажээ. Харин Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Т.Мөнхсайхан нь 2006-2016 он хүртэл ГССҮТ-д Их эмч, Үений дурангийн Нийгэмлэгийн захирал, Монголын түлэнхийн сангийн тэргүүлэгч, Олон улсын үе судлалын нийгэмлэгийн тэргүүлэгч, гишүүн зэрэг үүргийг хавсран гүйцэтгэж байгаа аж.

## 300 ортой төрөх эмнэлгийг концессоор барьж дуусгана

"Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих төсөл"-ийн концесс олгох уралдаант шалгаруулалтын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат танилцуулав. Төслийг "Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх" төрлөөр уралдаант шалгаруулалтын аргаар хэрэгжүүлэхээр Засгийн газар 2013 онд шийдвэрлэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 68 хувьтай байсан ч төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсноос ажил нь зогсоод байгаа юм. Төслийн уралдаант шалгаруулалтыг энэ оны тавдугаар сард зарласан бөгөөд нэг компани саналаа ирүүлээд байна. Иймээс цаашид уралдаант шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг Үндэсний хөгжлийн газарт даалгалаа. Төсөл хэрэгжвэл эрүүл мэндийн даатгалын сангаар эх, хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан, 140 ортой амаржих газар, хүүхдийн 160 ортой төрөлжсөн нарийн мэргэжлийн төв бүхий эх, хүүхдийн цогц эмнэлэгтэй болох юм.

NO STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

# Уналт





Н.БОЛД

Чехийн цаначин Ондрей Банк Уулын цанын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож байх үедээ уруудах хэсэгт осолдсоны улмаас тархи болон нүүрэндээ хүнд гэмтэл авсан юм. Энэхүү зургийг авсан зурагчин нь Кристиан Валграм. Тэрбээр Австрийн “Schoeder”-т төрж өссөн. Ахлах сургуулий төгссөний дараа “St. Peter am Kammersberg”-ийн их сургуульд дөрвөн жил суралцан 2000 онд төгссөн байна.

Сургуулиа төгссөний дараа цэргийн албанд татагджээ. Кристиан таван жил цэргийн алба хааж байхдаа зурагчны үүрэг гүйцэтгэдэг байсан нь түүнийг энэ салбар руу татагдан орох шалтгаан болов. 2008 оноос тэрбээр “GEPA” агентлагт зурагчнаар ажиллаж эхэлжээ. Кристиан хоёр охины аав бөгөөд Австрийн Гразийн ойролцоо “Eggersdorf” хэмээх жижигхэн хотод амьдардаг юм байна. Тэрбээр энэхүү зургийг 2015 оны хоёрдугаар сарын 8-нд авсан бөгөөд спортын ганцаарчилсан төрөлд анхны шагнал авсан бүтээлээр тодорсон юм.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр -5
Шөнө -16

Нөгөөдөр

Өдөр -9
Шөнө -15

## Өдрийн зурхай

**Билгийн тооллын 2**

**Үс засуулбал:** Хэл,ам,хэрүүл тэмцэл ирнэ

**Наран ургах, шингэх:** 08.20-17.08



*Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

ДУУЛГАХ СОНИН

## Д.Алтанхуяг Японы ГХЯ-ны өргөмжлөл хүртлээ

Монгол Улсын Гавьяат жүжигчин, Монгол Улсын Соёлын элч, балетчин Д.Алтанхуягт Япон улсын Гадаад хэргийн сайд Фүмио Кишида өргөмжлөл гардуулсан байна. Тус өргөмжлөлд “Балетын урлагаар дамжуулан Япон, Монгол орны харилцан ойлголцол, найрамдалт харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гавьяат зүтгэлийг тань гүнээ хүндэтгэн өргөмжлөл гардуулав” хэмээжээ. Монгол Улсын Гавьяат жүжигчин, Монгол Улсын Соёлын элч Д.Алтанхуяг нь 2001 онд Японы Токио хотноо болсон Ази, Номхон далайн тэмцээний алтан медаль хүртэж байсан. Тэрбээр энэхүү хоёр жилд нэг удаа зохион байгуулдаг Ази, Номхон далайн тэмцээнийг эх орондоо зохион байгуулахаар ажиллаж байгаа аж.

## “Домог-10 жил” ТОГЛОЛТ БОЛНО

“Татлагын холбоо”, “Хартай сарлаг”, “Түмэн агтны төвөргөөн” зэрэг монгол аялгууг эх орондоо төдийгүй дэлхий дахинаа сурталчлан таниулсан Монголын үндэсний урлагийн “Домог” хамтлаг “Домог-10 жил” хүндэтгэлийн ойн тоглолтоо ирэх сарын 2-нд “Корпорэйт” зочид буудлын концертын их танхимд толилуулах гэж байна. Тус хамтлагийн хүндэтгэлийн тоглолтын ерөнхий найруулагчаар Төрийн соёрхолт, Монгол Улсын Гавьяат жүжигчин Д.Сосорбарам ажиллаж байгаа аж. Мөн тоглолтод Улсын филармонийн симфони оркестр, Улаанбаатар чуулгын бүжигчид, “Хурд”, “Увертюра” хамтлаг болон уртын дуучин Г.Энхбаатар, Э.Болормаа, Б.Солонго, уран нугараач Г.Нямгэрэл нар оролцож, чуулгын хэмжээнд уран бүтээлээ толилуулах нь ээ.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

**Sco Mco**

Баатар болох гэсэн биш загнуулаад дуусав. Замын хажууд зогсжийсон чинь нэг машаан ирээд зогсонгуут нэг залуу буугаад гүйлээ. Араас нь настайвтар жолооч ах цонхоо нэгээд хүүе мөнгөө гэх нь тэр. Хөгшин хүн дээрэлхээд хөгийн амьтан бэ гэж бодох зуураа нөгөө залууг хавсраад унагаачихав. Залуу пид пад гээд өнхрөөд явчлаа. Жолооч ах ирснээ яадаг мал вэ гэж намайг загнав. Тэгсэн МӨНГӨНСҮХ гэдэг нэртэй хүүхэд нь болж тааравшд. Хаха.

СОНИРХУУЛАХАД

## Вудберн хамгийн залуудаа гоол оруулсан тамирчин боллоо



Английн алдарт “Ливерпүүл” клуб өнгөрсөн шөнө лигийн цомын 1/4 шигшээд доод лигийн “Лидс” клубтэй тулж, 2:0-ээр буулгаж авсан билээ. Энэ тоглолтын хоёр дахь гоолыг Бен Вудберн хэмээх залуу тоглогч оруулсан. Ингэснээр Уэльс хөлбөмбөгч “Ливерпүүл”-ийн түүхэнд хамгийн залуудаа гоол оруулсан тоглогч болж, Майкл Оуэний амжилтыг эвдлээ. Оуэн “Ливерпүүл”-ийн төлөө 17 нас 143 хоногтойдоо гоолдож байсан аж. Харин Вудберн 17 нас 45 хоногтойдоо гоолдсон юм.

